

Монгол улс: Сонгомол асуудлууд

Монгол улсын Сонгомол асуудлууд нэртэй судалгааны энэхүү өгүүллийг Олон Улсын Валютын Сангийн мэргэжилтнүүдийн баг бэлтгэсэн бөгөөд энэ нь гишүүн орнуудтай тогтмол явуулдаг зөвлөлдөх хэлэлцүүлэгт зориулан нөхцөл байдлыг тодорхойлсон баримт бичиг болдог. Энд тусгагдсэн мэдээлэл нь өгүүллийг бэлтгэж дууссан үе буюу **2008 оны 5-р сарын 19-ний байдлаарх** мэдээ мэдээлэлд үндэслэсэн болно. Энэ баримт бичигт илэрхийлсэн байр суурь нь мэргэжилтнүүдийн багийн байр суурь бөгөөд **Монгол улсын** Засгийн газар буюу ОУВС-гийн Гүйцэтгэх Захирлуудын Зөвлөлийн байр суурь болохгүй болохыг мэдэгдэж байна.

ОУВС-гийн ажлын хэсгийн тайлан болон бусад баримт бичгийг хэвлэн нийтлэх бодлогын хүрээнд зах зээлийн хувьд эмзэг мэдээ мэдээллийг тусгахгүй байж болно.

ОУВС-гийн хэвлэн нийтлэх бодлогын үнэлгээ хийхэд дэмжлэг болгох үүднээс уншигчдын зүгээс санал дүгнэлтээ чөлөөтэй илэрхийлэхийг дэмжиж Publicationpolicy@imf.org цахим шуудангийн хаягаар санал дүгнэлтийг хүлээн авч байна.

Энэхүү тайлан нь олон нийтэд нээлттэй бөгөөд доорх хаягаар авч болно:

Олон Улсын Валютын Сан • Хэвлэн нийтлэх алба

700 19th Street, N.W. • Washington, D.C. 20431

Утас: (202) 623 7430 • Факс: (202) 623 7201

Цахим-шуудан: publications@imf.org • Интернет хаяг: <http://www.imf.org>

Үнэ: нэг хувь нь 18.00 ам. доллар

Олон Улсын Валютын Сан

Вашингтон, К. Т.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН

МОНГОЛ УЛС

Сонгомол Асуудлууд ба Статистикийн Хавсралтууд

Бёнг Гюн Жанг, Тубагус Феридханусетяван (бүгд АНДГ),
Дэйхан Ким (ТГ), Гари Жоунс (СГ), Базарбай Ардак болон Буянхишиг Хулан
(Монгол дахь ОУВС-гийн Суурин төлөөлөгчийн газар) нар бэлтгэв.

Ази, Номхон далайн газар батлав

2008 оны 5 дугаар сарын 19

Агуулга

Хуудас

I. Монгол дахь Уул Уурхайн Салбарын Төсвийн Тогтолцоо	5
A. Танилцуулга.....	5
B. Зэс, алтны уурхайн төсвийн тогтолцоог загварчлах нь	6
C. Бусад орнуудтай хийсэн харьцуулалт болон татварын тогтолцооны өөр сонголтууд	13
D. Дүгнэлт.....	19
Ашигласан ном.....	21
II. Монгол дахь Төрийн Ажил эрхлэлт болон Цалин	22
A. Танилцуулга.....	22
B. Төрийн ажил эрхлэлт болон цалингийн талаарх сүүлийн үеийн хандлагууд	23
C. Бодлогын Чиглэлд Гарган Гол Дэвшилтүүд.....	29
D. Дүгнэлт.....	30
Ашигласан ном.....	32
III. Монгол дахь Хадгаламж, Зээлийн Хоршоод.....	33
A. Танилцуулга.....	33
B. Хямрал болохоос өмнөх ХЗХ-ны салбарын хөгжил	33
C. ХЗХ-ын Дампуурал.....	35
D. Хямралын Дараах Нөхцөл Байдал.....	37
E. Дүгнэлт	39
Ашигласан ном.....	40
IV. 2001 оны ЗГССГА-ыг Ашиглан Монгол Улсын Төсвийн Мэдээллийн Тухай Танилцуулга, Урьдчилсан Дүн	41
A. Ерөнхий асуудлууд	43

В. Үр дүн.....	44
С. Дараагийн алхамууд.....	47

Шигтгээнүүд

II.1 Төрийн албаны дунд хугацааны шинэчлэлийн стратеги.....	29
II.2 2007 оны Төрийн албаны тооллогын үр дүн.....	30
III.1 ХЗХ-ны тухай хуулийн төсөл.....	36
IV.1 Туршилтын судалгааны танилцуулга.....	42
IV.2 Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн товч.....	44
IV.3 2001 ЗГССГА тайлан болон үндсэн балансууд.....	48

Хүснэгтүүд

VI.1 Монгол Улс: Засгийн газрын балансын хөгжил, дэвшил (2004-06)
VI.2 Монгол Улс: Засгийн газрын нэгдсэн баланс, 2006
VI.3 Монгол Улс: Засгийн газрын үйл ажиллагааны тайлан (2001 ЗГССГА), 2006
VI.4 Монгол Улс: Засгийн газарт зориулсан Бэлэн мөнгөний эх үүсвэр болон хэрэглээний тухай тайлан (2001 ЗГССГА), 2007

Статистикийн Хавсралт Хүснэгтүүд

1. Үндсэн мэдээлэл, 2002-07
2. Өнөөгийн зах зээлийн үнээр ДНБ салбараар, 2002-07
3. 2005 оны тогтмол үнээр ДНБ салбараар, 2002-07
4. ДНБ-ий дефлятор салбараар, 2002-07
5. Өнөөгийн зах зээлийн үнээр Үндэсний нийт орлого болон хадгаламж, 2002-07
6. Хөдөө, аж ахуйн гол бүтээгдэхүүний гарц, 2002-07
7. Үйлдвэрлэл болон уул уурхайн үндсэн бүтээгдэхүүний гарц, 2002-07
8. Нийт үйлдвэрлэлийн ба уул уурхайн бүтээгдэхүүний гарц, 2002-07
9. Нүүрс олборлолтын салбар, 2002-07
10. Нефтийн импорт, 2002-07
11. Цахилгааны салбар, 2002-07
12. Ажил эрхлэлт салбараар, 2002-07
13. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс, 2002-07
14. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн инфляци, 2002-07
15. Жижиглэнгийн үнэ, 2002-07
16. Улсын үйлдвэрүүдийн хувьчлал, 2002-07
17. Засгийн газрын ажилтнуудын дундаж цалин, 2002-07
18. Ерөнхий засгийн газрын үйл ажиллагааны товч, 2002-07
19. Ерөнхий засгийн газрын орлого, 2002-07
20. Ерөнхий засгийн газрын зарлага, 2002-07
21. Ерөнхий засгийн газрын зарлага салбараар, 2002-07
22. Ерөнхий засгийн газрын нийгмийн зарлага, 2002-07

23. Татаас ба шилжүүлэг, 2002-07
24. Нийгмийн хамгаалал, нийгмийн тусламжийн сан, 2002-07
25. Нийгмийн хамгааллын халамжийг хүртэгсдийн тоо, 2002-07
26. Засгийн газрын ажил эрхлэлт ба цалин, 2002-07
27. Эрүүл мэндийн салбарын зарлага, 2002-07
28. Боловсролын салбарын зарлага, 2002-07
29. Мөнгөний бодлогын судалгаа, 2002-07
30. Монгол банкны баланс, 2002-07
31. Арилжааны банкуудын нэгдсэн баланс, 2002-07
32. Банкны зээлийн санхүүгийн бус салбарт олгосон хуваарилалт, 2002-07
33. Засгийн газарт олгосон цэвэр зээл, 2002-07
34. Зээлийн хүү, 2002-07
35. Банкны салбарын санхүүгийн орчны үзүүлэлтүүд, 2002-07
36. Төлбөрийн баланс, 2002-07
37. Экспортын түгээмэл бараа, бүтээгдэхүүний бүтэц, 2002-07
38. Импортын түгээмэл бараа, бүтээгдэхүүний бүтэц, 2002-07
39. Худалдааны чиглэл, 2002-07
40. Үйлчилгээ, орлогын данс, 2002-07
41. Дунд болон урт хугацааны зээлийн зарцуулалт, 2002-07
42. Богино хугацааны хөрөнгийн урсгал, 2002-07
43. Дотоодын зээл, зээлийн үйлчилгээ, 2002-07
44. Дотоодын хувьцааны зээл зээлдэгчээрээ, 2002-07
45. Монгол банкны албан ёсны нөөц, 2002-07
46. Арилжааны банкуудын гадаад валютын гүйлгээний сонгомол асуудлууд, 2002-07
47. Нэрлэсэн валютын ханш, 2002-07

I. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ТОГТОЛЦОО¹

A. Удиртгал

1. **Монгол Улсын уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлт, хөгжилд хувь нэмэр оруулж байгаа томоохон салбар юм.** Зэс, алт, нүүрс зэрэг үндсэн ашигт малтмалаас гадна төмөр, цинк, молибдени зэрэг ашигт малтмалыг олборлодог (Чакир ба Клемм, 2007). Зэс, алтны үнэ огцом, тогтмол өссөний ачаар 2007 онд уул уурхайн салбар ДНБ-ий 27½ хувийг, экспортын орлогын 64 хувийг бүрдүүлэхийн зэрэгцээ зэс, алт, нүүрсний борлуулалтаар улсын төсвийн орлогын 36½ хувийг бүрдүүлсэн байна. Уул уурхайн салбар нь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч тус салбар нь капиталд илүү суурилсан салбарын хувьд ажлын хүчний зөвхөн 4 хувийг бүрдүүлж байна.
2. **Дэлхийн зах зээл дээрх өндөр үнэ нь тодорхой хэмжээгээр эдийн засаг дахь уул уурхайн салбарын ач холбогдлыг нэмэгдүүлж байгаа ч Монгол Улсын ашигт малтмалын нөөц маш их бөгөөд дэлхийн зах зээл дээрх үнэ буурч хэвийн түвшиндөө хүрсэн үед ч энэхүү салбар нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд гол үүргийг гүйцэтгэсэн хэвээр байх болно.** Эдийн засгийн хувь хамгийн өндөр ач холбогдолтой, боловсруулах шатандаа явж буй ордын тоонд зэс, алтны нөөц бүхий (Айвенхоу Майнз, 2005 ба 2007) Оюу Толгой (ОТ), Таван Толгой болон Багануурын нүүрсний ордууд орох юм.²

Монгол Улс: Уул уурхайн салбарын ДНБ, төсвийн орлого, экспортод оруулах хувь нэмэр					
	2004	2005	2006	2007 Тооц.	2008 Төс.
	(хувиар)				
Ашигт малтмалын ДНБ					
Бодит өсөлт	34.3	10.9	6.3	1.7	1.4
Нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь	17.0	21.9	29.9	27.4	24.7
Ашигт малтмалын орлого					
ДНБ-д эзлэх хувь	3.7	4.0	10.5	14.7	13.6
Засгийн газрын нийт орлогын хувь	11.2	13.3	28.6	36.3	31.8
Ашигт малтмалын экспорт					
Нийт экспортод эзлэх хувь	63.7	70.7	70.4	64.0	63.9
Үүнээс: зэс	32.6	30.5	41.1	41.6	38.7
алт	27.5	31.0	17.5	12.0	15.7

Эх үүсвэр: Монгол Улсын эрх бүхий байгууллагууд ба ОУВС-гийн шинжээчдийн тооцоо.

3. **Уул уурхайн салбарын төсвийн тогтолцоог боловсруулахад хэд хэдэн онцлог асуудлууд байдаг.** Ашигт малтмалын нөөц нь нөхөн сэргээгдэдгүй бөгөөд уул уурхайн компаниуд болон Засгийн газар хооронд гардаг гол хурцадмал асуудлуудын нэг бол ашиг

¹ Дайхайн Ким бэлтгэв.

² Лиценз эзэмшигч болон Засгийн газрын хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээ хийх, Улсын Их Хурлаас соёрхон батлах явц удааширсны улмаас одоогоор ОТ уурхайг ашиглах үйл явц хойшлогдсоор байна. Хөрөнгө оруулалтын гэрээ нь Ашигт малтмалын тухай (2006) хуулийн хүрээнд хийж буй анхны гэрээ юм.

болон эрсдэлээ хуваах асуудал юм. Ийм учраас уул уурхайн салбарын төсвийн тогтолцоо нь Засгийн газрын хувьд өөрийн нөөцөөсөө боломжийн хэмжээгээр өндөр ашиг хүртэх, үүний зэрэгцээгээр тус салбарын боломжит хөрөнгө оруулагчдыг татах өрсөлдөх чадварыг баталгаажуулахад чиглэгдэх ёстой. Эдгээр хоёр зорилтуудыг тэгш авч үзсэнээр Монгол Улсын уул уурхайн салбар нь эдийн засгийн тулгамдсан бэрхшээлүүд, үүнд өргөн хүрээнд тархмал байгаа ядуурал, эдийн засгийг төрөлжүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай томоохон санхүүгийн эх үүсвэрийг хангах бололцоотой болох юм.

- 4. Энэхүү баримт бичиг нь зэс, алтны олборлолтоос улсын төсөвт орох орлогын бүтэц, хувь хэмжээ, орлогын мэдрэмж зэрэгт төсвийн тогтолцоо хэрхэн нөлөөлөхийг харуулж байгаа юм.** Энэхүү шинжилгээг ОТ төсөлтэй ижил төстэй зэс, алтны уурхайн жишээн дээр суурилан 2007 оны эцэст хүчин төгөлдөр байсан ашигт малтмалын татварын тогтолцоог ашиглан дүн шинжилгээ хийсэн юм (Нээлттэй нийгэм форум, 2007). Ердын нөхцөл байдалд татварын дарамт боломжийн түвшинд байгаа хэдий ч зэс, алтны салбарт ноогдуулж байгаа татварын дарамт олон улсын стандарттай харьцуулахад өндөр, ялангуяа ашигт малтмалын үнэ гэнэтийн ашгийн татвар ноогдуулах суурь үнээс давж гарсан тохиолдолд татварын дарамт өндөр байгаа нь дүн шинжилгээнээс харагдаж байна. Мөн түүнчлэн нөөцийн ашгийн татвар нь гэнэтийн ашгийн албан татвар болон улс хувь эзэмшин оролцох зэрэг хувилбаруудаас илүү дээр хувилбар гэдгийг илтгэж байна. Энэхүү баримт бичгийн үлдсэн хэсэг дараах байдлаар зохион байгуулагдсан болно. В хэсэгт Монгол Улсын уул уурхайн салбарын өнөөгийн төсвийн тогтолцоог шинжилсэн болно. Үүний зэрэгцээгээр одоогийн татварын тогтолцооны хүрээнд төслөөс улсын төсөвт орох орлого, ашигт малтмалын үнээс хамаарах төсвийн орлогын мэдрэмж болон прогрессив шинж чанарын хувьд өнөөгийн тогтолцоо хэр үр ашигтай байгаа зэргийн талаар хэлэлцэх юм. С хэсэгт Монгол Улсын өнөөгийн төсвийн тогтолцоог зэсийн томоохон үйлвэрлэгч орны тогтолцоотой харьцуулж, Монгол Улсын хувьд тогтолцооны шинэ хувилбарыг санал болгож байгаа юм. Сүүлийн хэсэгт дүгнэлт гаргав.

Б. Зэс, алтны уурхайн төсвийн тогтолцоог загварчлах нь

Уул уурхайн салбарын төсвийн тогтолцоо

- 5. Уул уурхайн салбарын өнөөгийн төсвийн тогтолцоо нь Ашигт малтмалын тухай хууль болон татварын тухай бусад хуулиар зохицуулагдаж байна.** Энэхүү тогтолцооны хүрээнд шууд хэлбэрээр ногдуулж буй татваруудад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), суутган тооцох татварууд (СТТ) болон гэнэтийн ашгийн татвар (ГАТ) зэрэг орж байна. Үүний зэрэгцээгээр хайгуулын болон ашиглалтын лицензын хураамжууд байгаа хэдий ч эдгээр бага ач холбогдолтой юм. Түүнчлэн гаалийн албан татвар болон НӨАТ зэрэг шууд бус татварыг уул уурхайн салбарт ногдуулдаг. Энэхүү тогтолцооны хүрээнд татварын журмыг баримтлана. Үүнд:

- **Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.** Ашигт малтмалын тухай хуулийн дагуу бүх металын нийт борлуулалтын орлогын 5 хувьтай тэнцэх татвар ногдуулна. Дотоодын зах зээл дээр борлуулсан буюу эрчим хүч гаргахад зориулагдсан нүүрс болон бусад түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын орлогод 2 ½ хувийн татвар ногдуулна.
- **Ах ахуйн нэгжийн орлогын албан татвар.** ААНОАТ-ыг татвар ногдуулах орлогын эхний 3 тэрбум төгрөг (өнөөгийн валютын ханшаар 2.6 сая ам.доллар)-т 10 хувийн татвар, 3 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнд 25 хувиар татвар ногдуулна. Мөн уг хуулиар тайлангаар гарсан алдагдлыг 2 жил дараалан албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно. Албан татвар ногдуулах орлогоос жил бүр хасагдах алдагдлын хэмжээ нь тухайн жилийн албан татвар ногдуулах орлогын дүнгийн 50 хувиас хэтрэхээргүй байна.
- **Гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газарт өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлэх татвар.** Ноогдол ашиг, ашигт малтмалын нөөц ашигласны, зээлийн хүү, лизингийн хүү, удирдлагын зардлаас олсон орлого зэрэгт Монгол Улсын ААНОАТ-ын тухай хуулийн дагуу 20 хувийн суутган тооцох татвар ногдуулна. Гэхдээ энэхүү татварын хэмжээг олон улсын гэрээгээр багасгаж болох бөгөөд тухайлбал, Канад Улстай байгуулсан гэрээний дагуу Канадын компаниудад төлж байгаа ноогдол ашгийн суутган тооцох татварыг 5 хувь хүртэл бууруулах боломжтой байдаг.
- **Гэнэтийн ашгийн татвар.** Экспортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс улбаалан зэс, алт олборлогч компаниудын ашгаас өндөр хувь хүртэх үүднээс гэнэтийн ашгийн татварыг анх 2006 онд нэвтрүүлсэн болно. Энэхүү татварыг Оросын газрын тосны татварын загвар дээр суурилан боловсруулсан бөгөөд Монгол Улсад олборлосон алт, зэсний баяжмалын борлуулалтын орлогод ногдуулдаг татвар юм.³ Зэсийн баяжмалын хувьд Лондонгийн Металын Ханшны зэсийн үнэ болон зэсийн суурь үнэ (нэг тонн нь 2600 ам.доллараар тогтоосон) болон хайлуулалтын зардал (2006 онд 1 метр тонн нь ойролцоогоор 1,580 ам.доллараар тооцсон) хоёрын зөрүүнд 68 хувийн татварыг ногдуулдаг. Алтны хувьд Монголбанкны алтны үнэ болон алтны суурь үнэ (нэг унц алт 500 ам.доллараар тогтоосон)-ийн зөрүүнд мөн адил хэмжээний татвар ногдуулна.⁴ ГАТ-ыг орлогын татвараас суутгадаг бөгөөд суурь үнийг индексжүүлээгүй.

³ Одоогийн байдлаар гэнэтийн ашгийн татварыг зэсийн баяжмал үйлдвэрлэгч Эрдэнэт үйлдвэрээс авдаг. Тус компанийн 51 хувийг Монгол Улсын Засгийн газар эзэмшдэг бол үлдсэн хувийг нь Оросын Засгийн газар эзэмшдэг юм. Харин алтны гэнэтийн ашгийн татварыг алт олборлодог хэд хэдэн жижиг компаниудаас цуглуулдаг бөгөөд эдгээр нь 2006 онд нийт гэнэтийн ашгийн татварын орлогын 4-5 хувийг бүрдүүлжээ. Бороо хэмээх алтны хамгийн том уурхай нь 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд байгуулсан Тогтвортой байдлын гэрээний дагуу татвараас чөлөөлөгддөг.

⁴ 2008 оны 3 дугаар сард нийтлэгдсэн “Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв байдлын тухай судалгаа, 2008”-тайланд тусгасан үнийн төсөөллөөр нэг тонн зэс 7,000 ам.доллар, нэг унц алтны үнэ 960 ам.доллар байна.

- **Импортын татвар.** Монгол Улс нь зөвхөн 5 хувийн импортын татвар авдаг. Гэсэн хэдий ч гаалийн хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчдын тэргүүлэх салбар эсвэл экспортод чиглэсэн аж үйлдвэрүүдэд ашиглах зорилгоор импортоор оруулж ирж буй тоног төхөөрөмж, суурь машин зэргийг импортын татвараас чөлөөлнө гэсэн хэд хэдэн заалтууд байдаг. Уул уурхайн салбар ч эдгээр хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх боломжтой юм.
 - **НӨАТ.** Одоогийн НӨАТ-ын тухай хууль 2007 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон бөгөөд татварыг хувь хэмжээг 15 хувиас 10 хувь хүртэл бууруулж, экспортын аж үйлдвэрлэлд чиглэсэн импортын бараа, бүтээгдэхүүн зэргийг татвараас чөлөөлөхийг зогсоосон юм. Одоогийн байдлаар НӨАТ-ыг уул уурхайн салбар болон бусад салбарт адилхан ногдуулж байгаа. Монголын уул уурхайн компаниуд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ ихэнх хувийг экспортод тэг хувийн татвар төлж гаргадаг. Уул уурхайн компаниуд мөн НӨАТ-ын буцаан олголтонд хамрагддаг.
6. **Ашигт малтмалын тухай хуулинд төр уул уурхайн төсөлд хувь эзэмшин оролцох, Монгол Улсын Засгийн газар нь уул уурхайн лизенз эзэмшигчтэй тогтвортой байдлын гэрээ байгуулах боломжтойг тусгасан.** Энэхүү хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр нөөцийг нь тогтоосон ордын 50 хүртэлх хувийг, өөр эх үүсвэрээр нөөцийг нь тогоосон ордын 34 хүртэлх хувийг эзэмших эрхтэй байдаг.⁵ Гэсэн хэдий ч энэхүү хуулийн дагуу Монгол Улсын Засгийн газар хувь эзэмшсэнийхээ төлөө уул уурхайн лиценз эзэмшигчдэд хэрхэн, яаж нөхөн олговор олгох нь тодорхойгүй байгаа юм. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн дагуу уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанийн хөрөнгө оруулалтын хэмжээ эхний 5 жилд 50 сая ам.доллороос илүү гарсан тохиолдолд үйл ажиллагааны тогтвортой нөхцөлийг хангах зорилгоор Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг зөвшөөрдөг. Тогтвортой байдлын гэрээний хугацаа анхны хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарах бөгөөд хамгийн ихдээ 30 жилээр байгуулах боломжтой юм.
7. **Ашигт малтмал болон ААНОАТ-ын тухай хуулинд зардал нөхөхтэй холбоотой татварын заалтуудыг тусгасан бөгөөд энэ нь төсвийн тогтолцоог тодорхойлогч чухал хүчин зүйл юм.** Ашигч малтмалын тухай хуулинд хайгуулын ажлын зардал болон уурхайн эдэлбэрийн ашиглалтанд бэлтгэсэн зардлыг үйлдвэрлэл эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд буюу тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд үйлдвэрлэлийн зардалд оруулан шулуун шугамын аргаар элэгдэл тооцно гэж заасан байна. ААНОАТ-ын хуулинд зааснаар уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг элэгддэг хөрөнгө гэж тооцож байгаа бөгөөд элэгдсэн хөрөнгийн зардлыг ашиглах хугацаанд нь шулуун шугамын аргаар элэгдэл тооцно гэж заасан. Их хэмжээний өр тавих үйл ажиллагааг хязгаарлах үүднээс ААНОАТ-ын тухай хуулинд өр болон хөрөнгийн харьцаа 3:1 –с илүү байгаа тохиолдолд өрийн хүүгийн зардлыг хасч тооцохыг хориглосон байна.

⁵ Одоогийн байдлаар төрийн хувь эзэмших асуудлыг Улсын Их Хурлаар дахин хэлэлцэж байгаа бөгөөд төрийн хувь хэмжээг өндөрсгөх магадлал өндөр байгаа.

Зэс, алт олборлох төсөл

8. Энэхүү баримт бичигт загварчлан тооцоолсон төслийн хэрэгжих хугацаа 45 жил бөгөөд энэ хугацаанд 20 ½ сая метр тонн зэс, 37 сая унц алт үйлдвэрлэж байгаа гэж төсөөлж үзье. Уурхайн үйл ажиллагаа 2008 онд эхлэнэ гэж тооцвол зэс болон алтыг 2011 онд олборлож эхлэнэ. 2018 он гэхэд жилдээ олборлож байгаа зэсийн хэмжээ хамгийн дээд цэгтээ буюу 924 мянга метр тоннд хүрэх бөгөөд улмаар дараагийн жилүүдэд олборлолтын хэмжээ аажмаар буурна. 2016 онд жилдээ олборлож байгаа алтны хэмжээ хамгийн дээд цэгтээ буюу 1,768 мянган унцэд хүрэх бөгөөд улмаар аажмаар буурч 2036 онд дахин өсч эхлэнэ. Уурхайн үйл ажиллагааны хугацаанд нийт олборлолт болон хөрөнгө оруулалтанд 7.7 сая ам.долларын зардал гаргахаар тооцоолсон байна.⁶ Анхны хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх буюу цэвэр мөнгөн урсгал нь ашигтай гартал 2.7 тэрбум ам.доллар шаардлагатай гэсэн тооцоо гарч байна.



9. “Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын тухай судалгаа” (ДЭЗТБТС)-нд тусгагдсан зэс, алтны төсөөллийг төсөөллийн эцсийн он болох 2013 он хүртэл, харин 2013 оноос хойш бодит тогтмол үнийг ашиглан суурь тооцоог хийсэн.⁷ Уурхайн үйл ажиллагаа явагдах хугацаанд нэг метр тонн зэсийн дундаж үнэ нь 3,084 ам.доллар, нэг унц алтны дундаж үнэ 940 ам.доллараар тооцов. Нэг метр тонн зэсийн баяжмалыг боловсруулахад 138 ам.доллар, элэгдлийг хассан үйл ажиллагааны дундаж зардлыг тооцоход нэг метр тонн зэсийн баяжмалд 261 ам.доллар ногдож байна. Дээрх зардал нь зэс, алтны үнээс үл хамаарна.

⁶ Энэхүү баримт бичигт өөрөөр заагаагүй бол ам.доллар гэдэг нь 2007 оны нэрлэсэн ам. долларыг зааж байна.

⁷ Энэхүү баримт бичигт 2008 оны 3 дугаар сард хэвлэгдсэн ДЭЗТБТС-ны үнийн төсөөллийг ашигласан.

Загварчилсан тооцоо	
Баяжмалын нийт үйлдвэрлэл	66.4 сая мтонн
Нийт баяжмалын зэсийн эзлэх хэмжээ	20.5 сая мтонн
Нийт баяжмалын алтны эзлэх хэмжээ	36.9 сая унц
Зэсийн дундаж үнэ	нэг тонн зэс 3,084 тогтмол ханштай ам.доллар
Алтны дундаж үнэ	нэг унц алт 940 тогтмол ханштай ам.доллар
Боловсруулалтын зардал	нэг тонн баяжмал 138 тогтмол ханштай ам.доллар
Элэгдийг тооцсон үйл ажиллагааны зардал	нэг тонн баяжмал 261 тогтмол ханштай ам.доллар
Үйл ажиллагаагаа эхлүүлэх хугацаа	3 жил
Хэдэн жилийн дараа ашигтай ажиллах	5 жил
Дээрх хугацаанд шаардлагатай хөрөнгө оруулалт	2.8 тэрбум тогтмол ханштай ам.доллар
Эх сурвалж: Монголын эрх бүхий байгууллагууд, ОУВС-гийн ДЭЗТБТС.	

Төслийн бэлэн мөнгөний урсгал ба Засгийн газрын орлого



10. Симуляцийн дүнгээр бэлэн мөнгөний цэвэр урсгал 60 тэрбум ам.долларт хүрэх бөгөөд үүнээс Монгол Улсын Засгийн газар 47 тэрбум ам.долларыг хүлээн авна.⁸ Төслийн дотоод өгөөжийн түвшин (ДӨТ) 21 хувь буюу их ашигтай тооцоо гарч байна. 10 хувиар тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (ӨЦҮЦ10) 9.7 тэрбум болж байгаа бөгөөд Засгийн газрын хувь 8.1 тэрбум болж байна. Засгийн газар нь нийт ашгийн 60 хувийг хүртэх тооцоо гарч байгаа бөгөөд энэ нь 2007 оны нэрлэсэн ДНБ (3.9 тэрбум ам.доллар)-ийг хоёр нугалсантай тэнцэх юм.⁹

⁸ Төслийн үйл ажиллагааг эхлүүлэх үед Монгол Улсын Засгийн газар уурхайн 34 хувийг эзэмшинэ гэж тооцоолсон бөгөөд дээрх хэмжээний хувийг үргэлжлүүлэн эзэмших хүсэлтэй байгаа тохиолдолд Засгийн газар ирээдүйд гарах хөрөнгийн санхүүжилтийг 1/3-ыг хийх ажлыг хариуцна. Засгийн газрын оруулах санхүүжилтийн хувь хэмжээний хувь загварчилсан төслийн хүрээнд хувийн салбарын түншүүд нь Засгийн газрын оруулах ёстой санхүүжилтийг хийх бөгөөд Засгийн газар нь өөрийн санхүүжилт (хуримтлагдсан хүүг нь нэмээд)-ийг хувьцааныхаа ногдол ашгийн хөрөнгөөс төлнө гэж тооцоолсон юм. Өрийн хүүг LIBOR+3.3 хувиар тооцно. Төслийн хүрээнд Засгийн газар нь хуримтлуулсан өрийн хүүгээ төлөхөд хангалттай ашиг олоогүй тохиолдолд Засгийн газар үүссэн өрийг (nonrecourse loan) барагдуулах албагүй юм.

⁹ Нийт үр өгөөж гэж нийт орлогоос үйл ажиллагааны зардал болон татвар, өрийн үйлчилгээ, хөрөнгө оруулагчдад олгох шагнал, урамшууллын зардлыг хасаж тооцсон дүнг хэлнэ. Төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй тул энэ судалгаанд нийт үр өгөөж гэж нийт орлогоос үйл ажиллагааны зардлыг хассан дүнг хэлэх юм.

Бэлэн мөнгөний урсгал ба Засгийн газрын орлого				
Татвар ногдуулахаас өмнөх ДӨТ (хувь)	бодит	33		
Татвар ногдуулсны дараах ДӨТ (хувь)	бодит	21		
Хямдралын хувь		0	5	10
Төслийн ӨЦҮЦ	сая ам.доллар	59,632	21,702	9,723
Зээлдүүлэгчийн ӨЦҮЦ	сая ам.доллар	721	167	-187
Хөрөнгө оруулагчийн ӨЦҮЦ	сая ам.доллар	20,670	7,799	1,790
Засгийн газрын ӨЦҮЦ	сая ам.доллар	38,240	13,736	8,120
Нийт үр өгөөж	сая ам.доллар	67,373	26,690	13,547
		(хувиар)		
Нийт үр өгөөж дахь Засгийн газрын хувь	бодит	69	64	60
Үүнээс ГАТ				31
ААНОАТ				12
Ноогдол ашиг				9
Нөөц ашигласны төлбөр				6
Эх сурвалж: Валютын сангийн шинжээчдийн тооцоо				

11. Засгийн газрын жилийн орлого 2018 он гэхэд хамгийн дээд цэгтээ буюу ДНБ-ий 23 хувь (2.25 тэрбум ам.доллар)-д хүрэх бөгөөд цаашид буурах тооцоо гарч байна. Төсвийн орлогын томоохон хэсгийн ГАТ бүрдүүлж байгаа бөгөөд түүний дараагаар ААНОАТ, ногдол ашиг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг орж байгааг дүн шинжилгээнээс харж болно. Компаниудын зэс, алтны экспортын өндөр үнийн ашгаас төсөвт авах зорилгоор ГАТ-ыг нэвтрүүлсэн хэдий ч нэмэлт орлогоос хувь хүртэх арга хэрэгслийн хувьд энэ нь хэд хэдэн сул талтай юм (дэлгэрэнгүйг В хэсгээс үзнэ үү). Ялангуяа, татвар ногдуулах суурь үнэ (нэг метр тонн зэс 2,600 ам.доллар, нэг унц алтны 500 ам.доллар)-ийг индексжүүлээгүйгээс инфляцийн түвшин өндөр байгаа тохиолдолд татварын дарамтыг ихэсгэх, хөрөнгө оруулалтын болон бусад зардлаа нөхөх боломжгүй нөхцөлд хүргэх магадлалтай юм.¹⁰




Өнөөгийн төсвийн тогтолцооны прогрессив шинж

¹⁰ Тус загварт нийт төсвийн орлогын ГАТ-ын хувь хэмжээ нэмэгдэж байгаа үндсэн шалтгаан юм.

12. Ашигт малтмалын үнэ өндөр байгаа тохиолдолд төслийг хэрэгжүүлснээр Засгийн газрын хувьд төдийгүй хөрөнгө оруулагчийн хувьд ихээхэн хэмжээний эдийн засгийн үр өгөөжийг бий болгох төлөвтэй байна. Бизнес төлөвлөгөөний ашгийг харуулах уламжлалт хэмжигдэхүүн болох төсөөлсөн ДӨТ-ийн мэдрэмжийг үнэлэхийн тулд 10 хувиар хямдруулсан нийт өгөөж (НӨ10) дэх Монгол Улсын Засгийн газрын хувь, зэсийн үнийг олон янзаар төсөөлөн тооцсон болно.¹¹ Нэг тонн зэсийн дундаж үнэ 2,775 ам.доллар (нэг паунд нь 1.26 ам.доллар), алтны дундаж үнэ 940 ам.доллар байгаа тохиолдолд татвар ногдуулсны дараах ДӨТ 20 хувьд хүрэх бөгөөд энэ нь уул уурхайн салбарын хувьд сайн ашигтай байхыг харуулж байна. Гэсэн хэдий ч саяхан шинээр үйлчилж эхэлсэн татварын прогрессив тогтолцооноос улбаалан татвар ногдуулсны дараах ДӨТ зэсийн үнэ, татвар ногдуулахаас өмнөх ДӨТ -тэй адил хэмжээгээр өсөхгүй юм.

Зэсийн үнэ (ам.доллар/тонн)	1,850	2,159	2,467	2,775	3,084	3,392	3,701	4,009	4,317
Татвар ногдуулахаас өмнөх	25	27	29	31	33	35	36	38	39
Татвар ногдуулсны дараах ДӨТ (хувиар)	16	18	19	20	21	22	22	23	24
ЗГ-ын хувь (хувиар)	50	52	54	57	60	62	64	65	67



13. Энэхүү шинжилгээгээр ГАТ-аас шалтгаалан Монгол улсын уул уурхайн салбарын өнөөгийн төсвийн тогтолцоо прогрессив шинжтэй гэдгийг харуулж байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, импортын татвар, ноогдол ашгийн суутган татвар зэрэг нь регрессив (+ “Ашигт малтмалын нөөц ашигласны хураамж” хүснэгт) шинжтэй байна. Татвар ногдуулахаас өмнөх ДӨТ 28 хувьд (зэсийн үнэ 2,313 ам.доллар) хүрэх хүртэл ААНОАТ болон ногдол ашгийг нэмснээр систем нь прогрессив байгаа бөгөөд ихэнх тохиолдолд ААНОАТ болон ногдол ашгийг тооцохдоо ГАТ-ийг хасаж тооцдогийн улмаас ДӨТ тооцож үзэхэд эдгээр орлого нь прогрессив буюу өсөх нэмэгдэх хандлагатай

¹¹ Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал зэрэг хэд хэдэн хүчин зүйл татвар ногдуулахаас өмнөх ДӨҮЦ -д нөлөөлөх магадлалтай. Энэхүү баримт бичигт бид үнээс хамаарсан өөрчлөлтүүдийг тооцов.

байдаг.¹² Ерөнхийдөө, НӨ10 хувь, зэсийн үнэ 1850 ам.доллар (татвар ногдуулахаас өмнөх ДӨХ 25 хувь) байгаа тохиолдолд МУЗГ-ын эзэмшлийн хувь 50 хувиас нэмэгдэж, зэсийн үнэ 4,009 ам.доллар (татвар ногдуулахаас өмнөх ДӨХ 38 хувь) байгаа тохиолдолд 65 хувьд хүрнэ.

В. Бусад орнуудтай хийсэн харьцуулалт болон татварын тогтолцооны өөр хувилбарууд

Төсвийн тогтолцоог өөр орнуудын жишигтэй харьцуулах нь

14. Монгол Улсын уул уурхайн салбарт үйлчилж буй татварын ерөнхий тогтолцоо нь ГАТ-ын тусгай заалтуудыг үл оролцуулбал оновчтой мэт байна. Хэдийгээр Монгол Улсын ашигт малтмалын нөөц ашигласны 5 хувийн татвар олон улсын жишигтэй харьцуулахад бага зэрэг өндөр мэт боловч хөрөнгийн зардлыг чөлөөтэй нөхөх боломжийг олгож байгаа 25 хувийн орлогын татварыг оролцуулан дүгнэхэд татварын дарамт бусад улсуудынхтай (ГАТ-ыг оролцуулаагүй үйлчилж буй татварын ахиуц түвшин (ҮБТАТ) 32.3 хувь) адил түвшинд байгаа юм. Гэвч зэс, алтны үнэ нэг доллараас илүүтэй нэмэгдэхэд ГАТ нь, ялангуяа ГАТ-ын суурь үнэ бага түвшинд (нэрлэсэн үнээр нэг метр тонн нь 2,600 ам.доллараар) тогтоогдсон тохиолдолд татварын ахиуц түвшинг (81 хүртэлх хувь хүртэл) өсгөхөөр байна.¹³

Бусад орнуудтай хийсэн харьцуулалт: Үйлчилж буй татварын ахиуц түвшин					
	Монгол Улс	Перу	Өмнөд Африк	Замби 1/	Австрали
	Хувиар				
Нөөц ашигласны төлбөр	5.0	3.0 2/	2.0 3/	3.0	2.5 4/
ГАТ	68.0	8.0 5/	0.0	50.0 6/	0
ААНОАТ	25.0	32.0 7/	30.0 8/	30.0	0.3
Ногдол ашгаас суутгах татвар (НАСТ)	5.0 9/	4.1	12.5	15.0	0
ГАТ-гүй ҮБТАТ	32.3	36.9
ҮБТАТ	80.8	34.3	40.0	72.0	31.8

1/ 2008 оны 4 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон.

2/ Жилийн орлого 120 сая ам.доллараас их тохиолдолд.

3/ 2007 оны нөөц ашигласны татварын тухай хуулийн төсөл дээр үндэслэв.

4/ Зэсийн баяжмалын хувьд 2.5 хувь, боловсруулсан зэсийн хувьд 5 хувь.

5/ 8 хувийн ажилчдын ашгийн хуваарилалтыг татвар тооцох үйл явцад суутгадаг бөгөөд татварын дарамт биш юм.

6/ Зэсийн үнэ нэг паунд нь 2.5-3 ам.доллар (нэг метр тонн нь 5,510 ам.доллар) бол 25 хувь; дараагийн 50 центэнд 50 хувь, бөгөөд нэг паунд нь 3.5 ам.доллараас их бол 75 хувь.

7/ Тогтвортой байдлын гэрээгээр хамгаалагдсан татвар төлөгч нар ААНОАТ дээр нэмэлт 2 хувийн хураамж төлөх ёстой.


8/ Үүний зэрэгцээгээр бусад төрлийн орлогын татварын хувь хэмжээ нь татварт төлөх орлого болон нийт орлогын харьцаанаас шалтгаална.

9/ 20 хувийн НАСТ-ыг гэрээ байгуулан бууруулж болно. Канадын Татварын Гэрээнд Канадын компанид төлөх НАСТ 5 хувь хүртлээ бууурах боломжтой гэж заасан байдаг. Энэхүү бууруулсан хувь хэмжээ нь Канадын Айванхоу Майнзын ОТ уурхайд ч хамаарч байна.

¹² Үнэ тодорхой түвшнөөс дээш өссөнөөр ГАТ-ын төлбөр нь ЗГ-т төлөх ААНОАТ болон ногдол ашгийн суурийг багасгадаг.

¹³ Төслийн тодорхой хувийг эзэмших гэсэн Засгийн газрын хүсэл нь Монгол Улсын төсвийн тогтолцооны өрсөлдөх чадварыг бууруулах бөгөөд үүний үр дагаварыг тооцоолох хэцүү юм.

15. Харьцуулалт хийсэн бусад татварын тогтолцооноос Монгол Улсын өнөөгийн татварын тогтолцоон дор Засгийн газрын (НӨ10) эзэмших хувь хэмжээ өндөр байгаа бөгөөд илүү өсөн нэмэгдэх хандлагатай байгаа ч үүнд зөв тайлбар хийх шаардлагатай юм. Татвар ногдуулахаас өмнөх ДӨТ-г тооцож үзэхэд Монгол Улсад засгийн газрын эзэмших хувь хэмжээ өндөр байгаа бөгөөд ашиг нэмэгдэх тутамд засгийн газрын эзэмших хувь хэмжээ бусад орныхоос илүү хурдан өсөж байгаа.¹⁴ Уурхайн чанар, ашиглалтын болон үйл ажиллагааны зардлын бүтэц, шууд бус татвар, зардлаа нөхөх, татвараас чөлөөлөгдөх зэрэг тухайн улсын татварын онцлогоос хамаарсан олон янзын түгээмэл бэрхшээлүүдээс үүдэн олон улсын жишигт хийсэн харьцуулалтанд томоохон зөрүү гардаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Ялангуяа, уурхайн олборлолт хийх төслийн ашигтай ажиллагааг илтгэдэг татвар ногдуулсны дараах ДӨТ нь засгийн газрын эзэмшлийн хувь хэмжээ өндөр байгаагаас үр хамааран зөв зохистой хэмжээнд байгаа явдал юм. Түүнчлэн эдгээр үнэлгээ нь тодорхой дүгнэлтүүд дээр үндэслэсэн бөгөөд бусад уурхайн болон бусад ашигт малтмалд заавал хамаарах ёсгүй юм.¹⁵ Улс орон өөрийн уул уурхайн салбартаа олон улсын уул уурхайн компаниудын сонирхлыг татаж чадах эсэх асуудлаар зах зээлийн мэдрэмжийн тест авбал илүү дэлгэрэнгүй хариу өгөх магадлалтай юм.



Бусад орнуудтай хийсэн харьцуулалт: Уул уурхайн салбарын ХӨ татах чадамжийн зэрэглэл

	Он	Монгол Улс	Австрали 1/	Чили	Перу	Замби
Бодлогын үнэлгээ	2005-06	33/64	19/64	4/64	44/64	57/64
	2006-07	62/65	12/65	27/65	52/65	50/65
Ашигт малтмалын үнэлгээ	2005-06	3/64	19/64	1/64	43/64	53/64
	2006-07	58/65	15/65	8/65	41/65	32/65

Эх үүсвэр: Фрейзерийн Хүрээлэн Уул уурхайн компаниудын жил бүрийн судалгаа 2006/2007
1/7 хууль, тогтоомжийн дундаж.

¹⁴ Энэхүү загварчлалд төсөөлсөн нэг метр тонн зэсийн дундаж үнэ 1,542- 4,009 ам.долларын хооронд байгаа юм. Үнийн энэ цар хүрээнд байгаа тохиолдолд Замби Улсын ГАТ ихэнх хугацаа болон үнэ хувьд хүчин төгөлдөр бус байх болно.

¹⁵ Тус шинжилгээнд засгийн газрын эзэмшлийн хувь хэмжээ өндөр байгаа нь зөвхөн зэс, алтны борлуулалтад хамаарах ГАТ болон улс хувь эзэмших зэргээс улбаатай юм.

16. ГАТ-ыг нэвтрүүлсэн явдал, Засгийн газар уул уурхайн төслийн эзэмшлийн хувиа хэрхэн санхүүжүүлэх талаарх тодорхойгүй байдал, мөн түүнчлэн уул уурхайн салбарын тогтолцооны дунд хугацааны тогтвортой байдлын тухай асуудлууд нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдыг татах ойлголтод нөлөөлсөн байна. Саяхан авсан Фрейзерийн Хүрээлэнгийн судалгааны дагуу Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин дахь хөрөнгө оруулагчдыг татах чадамж нь 2005/06 онд үнэлгээгээрээ судалгааны дунд хэсэгт байсан бол 2006/07 онд тус судалгааны сүүлд орсон байна.¹⁶ Ашигт малтмал олборлох салбарт хөрөнгө оруулагчдын татах чадамжийн тухай судалгааны жагсаалтад Монгол Улс жагсаалтын дээд хэсгээс доод хэсэгрүү шилжсэн байна.¹⁷ Энэ асуудлаар хөрөнгө оруулагчдын зүгээс санал бодлоо илэрхийлсэн боловч 2007 онд уул уурхайн салбарын хайгуулын ажлын зардал 280 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

17. Монгол Улсын хөрөнгө оруулагчдыг татах чадамжийг одоогийн байдлаар үйлчилж байгаа ГАТ болон улсын хувь эзэмшлийн заалтад өөрчлөлт оруулснаар нэмэгдүүлж болох юм. Төсвийн тогтолцоонд саяхан оруулсан өөрчлөлтүүдээс улбаалан Монгол Улсын бизнесийн орчны тогтвортой байдал, мөн түүчлэн ил тод байдлын тухай асуудлууд хөндөгдсөн юм. Үүний зэрэгцээгээр ГАТ нь орлого хуваарилах арга хэмжээний хувьд хэд хэдэн бүтцийн сул талуудтай. Үүнд, ГАТ нь зардлыг тооцдоггүй¹⁸, ахиуц татварын хувь хэмжээ өндөр, татвар нь дотоодын хайлуулах болон боловсруулах үйлдвэр барихад татаас маягаар ашиглагдсан¹⁹. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хэрвээ ГАТ хэвээр байгаа тохиолдолд татварын хувь хэмжээг бууруулах, АНУ-ын ДНБ-ий дефляторд орж байгаа өөрчлөлтөөс хамааран жил болгон суурь үнийг өөрчилж байх, бүх төрлийн зэсийн борлуулалтанд татвар ногдуулах зэрэг арга хэмжээг авч болох юм. Уул уурхайн салбарын төсвийн тогтолцооны тодорхойгүй байдлыг бууруулах үүднээс Ашигт малтмалын тухай хуулинд засгийн газрын хувь эзэмшлийн нөхцлийг тодруулах шаардлагатай.²⁰


¹⁶ Фрейзерийн хүрээлэнгийн тайланг үзнэ үү (2007). Судалгаанд Антарктикаас бусад дэлхийн бүх тив дээрх 65 хууль, эрх зүйн орчинг хамруулсан бөгөөд үүнд Канад, Австрали болон АНУ-ын эрх зүйн орчинг мөн адил хамруулсан болно. Монгол Улсын индексийг тооцоходоо гэрээгээр 20 хувийн ноогдол ашгийн суутгалын татварыг бууруулж болох нөхцлийг харгалзан үзээгүй болно.

¹⁷ Монгол Улс ялангуяа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, тогтоомжийн тайлбар, хэрэгжилт, зохицуулалтын механизм давхардсан буюу уялдаагүй, татварын тогтолцоо, дэд бүтэц болон нийгэм, эдийн засгийн гэрээ зэрэг тодорхойгүй асуудлуудаар доогуур байр эзэлсэн байна.

¹⁸ Энэ нь ГАТ гажуудал бий болгох үндсэн шалтгаан юм. Одоогийн баримтлаж байгаа дүрэм, журмын дагуу зэсийн үнэ өссөн хэдий ч зардал өссөний улмаас компаниудын ашиг буурч байгаа тохиолдолд ч ГАТ-ын дарамт өсөх юм. Эсрэгээрээ, өндөр ашигтай ажиллаж байгаа компани нь зардлаа бууруулсны улмаас ашгаа нэмэгдүүлж байгаа бол ГАТ-т хамрагдахгүй юм.

¹⁹ ГАТ-ыг зэсийн хүдэр болон баяжмалын борлуулалтаас авч байгаа ч тус татварыг дотоодын зах зээл дээр боловсруулсан зэсийн борлуулалтанд ногдуулдаггүй бөгөөд энэ нь дотооддоо хайлуулах болон боловсруулах үйлдвэр барих түлхэц болгох юм.

²⁰ Төсөлд хувь эзэмшин оролцох нь Засгийн газрын байр сууринаас авч үзвэл хэд хэдэн дутагдалтай юм. (үргэжлэл дараагийн хуудсанд).



Орлогын хуваарилалт хийх бусад арга хэлбэрүүд

18. Хамгийн ашигтай төслийн давуу талуудыг татварын бусад арга хэрэгслийг хэрэглэн хамгийн үр ашигтай байдлаар ашиглах боломжтой юм. Дараах чухал зарчмыг хангаж байгаа бол орлого хуваарилах нэмэлт арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй юм. Үүнд:

- Шаардлагатай үр өгөөжийг хүртэхийн тулд хөрөнгө оруулагчийн хувьд алдагдал авчрах, ашиг хүртэх боломжийг хойшлуулж болзошгүй эрсдлийг нэмэгдүүлэхгүй байх.
- Өндөр ашигтай төслөөс Засгийн газар хангалттай хэмжээний нэмэлт орлогыг олдог байх ёстой. Ингэснээрээ Засгийн газар болон олон нийтэд төсвийн тогтолцооны шудрага байдлыг илтгэх, улмаар хөрөнгө оруулалтын орчинд тогтвортой байдлыг бий болгоход хувь нэмэр оруулах юм.
- Үйл ажиллагаагаа дүрэм, журмын дагуу явуулдаг, ил тод, хэрэгжүүлэхэд хялбар байх.
- Шинээр бий болсон тохиолдол болгонд хэлэлцээ хийхийг шаардах ёсгүй бөгөөд үүнийг өөгшүүлэх ёсгүй.

Энэхүү баримт бичиг нь нөөцийн ашгийн татвар (НАТ) буюу ашгийн төлөөх прогрессив татварын загварыг ашиглав.²¹


Үүнд, (i) засгийн газар өөрийн хувьд эрсдэл бий болгож байгаа, (ii) ногдол ашгийг хэзээ ч авахгүй гэж тооцоолбол татвар ногдуулах нь орлогоо нэмэгдүүлэх илүү үр ашигтай хувилбар байж болох юм; (iii) засгийн газар хувь эзэмшнээр тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн төслийн санхүүжүүлэхэд шаардлагатай байсан хөрөнгийг өөр зүйлд зарах шаардлага гарах юм; (iv) Засгийн газрын хувьцаа эзэмшигч болон зохицуулагчийн үүргүүд хоорондоо зөрчилдөж болзошгүй юм.

²¹ Уул уурхайн салбарт түгээмэл ашиглагдадгүй ч засгийн газрын зүгээс төсвийн тогтолцооны нэмэлт хувилбар болгон бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-г судлаж байгаа гэдгийг ОУВС-ийг шинжээчид ойлгож байгаа. Бүтээгдэхүүн хуваах бүтэц маш хялбар бөгөөд БХГ-нд (i) засгийн газарт төлөх нөөц ашигласны төлбөр, (ii) нийт бүтээгдэхүүний тодорхой хэсгийг зардлаа нөхөх зорилгоор гэрээлэгч өөртөө үлдээж болно, (iii) бүтээгдэхүүний үлдсэн хэсгийг засгийн газар болон гэрээлэгчийн хооронд хуваарилах томъёоллыг

19. Сайн боловсруулсан тохиолдолд НАТ нь бусад нэмэгдэл татварын хувилбарууд болох хувьсах орлогын татвар буюу буцаан төлөх харьцаан дээр суурилсан илүүдэл ашгийн татвар зэргээс илүү үр ашигтай байдаг. НАТ-ийн тооцооны үндсэн зарчим нь:

НАТ гэдэг нь зардлыг нөхсөний дараагаар урьдчилан тодорхойлсон өгөөжийн түвшинөөс (өөрөөр “хуримтлалын хувь” гэдэг) илүү гарсан бэлэн мөнгөн эерэг урсгалын дүнд ноогдуулж буй пропорциональ татвар юм.

- Олборлолтын зардлыг тооцсон боловч хүүг тооцоогүй бүх хөрөнгийн, үйл ажиллагааны зардал болон бусад татварыг өнөөгийн орлогоос хасаж тооцно. Уурхайн үйлдвэрлэл эхэлснээс үеэс эхлэн жил болгон хасах дүнтэй гарсан цэвэр мөнгөн зардлын балансанд хуримтлалын хүүг ашиглана.²²



- Орлого орсноор хуримтлагдсан хасах дүнтэй мөнгөн урсгал нь нэмэх дүнтэй гарснаар хэлэлцэн тохирсон буюу хууль, тогтоомжоор тогтоосон НАТ хувь хэмжээгээр татвар тооцно. (хувь ААНОАТ-аас багагүй байдаг).

“ашгийн бүтээгдэхүүн” гэдэг. Хэрвээ ашгийн бүтээгдэхүүнийг хуваах үйл явц ДӨТ-д суурилсан бөгөөд гэрээлэгч үндсэн ашгийг олсон бол БХГ-г НАТ-тай дууриалган боловсруулж болох юм.

²² Энэхүү журмаар НАТ-ыг тооцохдоо ААНОАТ-ыг хасагчаар тооцсон байна. Орлогын татварыг тооцохдоо эхлээд НАТ-ыг тооцоод дараа нь түүнийг хасагчаар тооцож болно.



- Тухайн жилдээ татвараа төлсөн бол хуримтлагдсан мөнгөн урсгалын балансыг дараагийн жилд нь тэгээр тогтооно. Энэ нь нэг мөнгөн урсгалд давхар татвар ногдуулахгүй зорилготой юм. Нэмэх дүнтэй гарсан цэвэр мөнгөн урсгалд дараагийн жилд нь НАТ-ын хувь хэмжээгээр татвар ногдуулна. Хэрвээ дараагийн жилд нь цэвэр мөнгөн урсгал хасах дүнтэй гарсан бол орлого нэмэгдсэнээр хасах дүнтэй хуримтлагдсан мөнгөн урсгал нэмэх дүнд шилжтэл НАТ-ыг төлөхгүй.
- НАТ нь санхүүжилтийн арга зүйн хувьд дундыг баримтлагч бөгөөд учир нь ерөнхий өгөөжийн хүүгээр төлөөлүүлсэн хуримтлалын хүү нь өрийн хүү болон хөрөнгийн өгөөжийг хамардаг.


20. НАТ нь ашгийн төлөө бөгөөд хөрөнгө оруулагчийн өгөөжийн хувь болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг шууд байдлаар харгалзан үздэг. Ийм учраас энэ нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл болон уурхайг хаахад ямарваа гажуудал үүсгэдэггүй бөгөөд үүний зэрэгцээгээр засгийн газарт эдийн засгийн томоохон өгөөжийг хуримтлуулж өгдөг. Хуримтлалын хүү болон татварын хувийг тогтоох нь амаргүй бөгөөд орлого саатах, хөрөнгийн (буюу үйл ажиллагааны) зардал хэтрэх зэрэг эрсдлийг засгийн газрын зүгээс даах шаардлага НАТ –ын үед үүсдэг.²³

21. НАТ-ын тогтолцоо нь өнөөгийн тогтолцооноос илүү прогрессив шинжтэй бөгөөд татварын нийт дарамт нь бага байгаа нь симуляцийн дүнгээр харагдаж байна. Нэмэх дүнтэй мөнгөн урсгал нь 15, 25 болон 35 хувийн хуримтлалын хүүгээс буюу өгөөжийн 15, 25 болон 35 хувиас давсан бол тус тус 25, 35 болон 45 хувийн татвар ногдуулахаар загварт тусгасан.²⁴ Тус загварт ГАТ болон улсын хувьд эзэмшил байхгүйгээр төсөөлсөн. В хэсэгт

²³ Эдгээр бэрхшээлүүдээс үл хамааран сүүлийн үед татварын удирдлага бэхжиж хууль хэрэгжилт сайжирсантай холбогдуулан НАТ-ыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх удирдлагын зохих чадавхи Монгол улсад бий гэж үзэж байна.

²⁴ Хуримтлалын хүү, татварын холбогдох хувь хэмжээ зэрэг татварын үзүүлэлтүүдийг бодлогын зорилтуудад үндэслэн тогтоох ёстой юм. Тиймээс энэхүү судалгаагаар авч үзсэн үзүүлэлтүүд нь зөвхөн жишээ бөгөөд ОУВС-гийн тодорхой зөвлөмж гэж ойлгож үл болно.

ашиглагдсан суурь үзүүлэлтүүдийн дагуу НАТ-ын тогтолцоонд засгийн газрын эзэмших хувь нь нийт өгөөжийн (НӨ10) 47 хувь бөгөөд НАТ нь засгийн газрын орлогын ӨЦҮЦ-ийн 40 хувийг эзлэхээр байна. Тус засгийн газрын хувь эзэмших хэмжээ нь өнөөгийн тогтолцооныхтой харьцуулбал 13 нэгж хувиар доогуур байгаа ч төслийн үйл ажиллагаа ашигтай болох тусам энэхүү ялгаа арилж байгаа. Үүгээр зогсохгүй татварын суурь нь төслийн ашгаар буюу тодорхой тогтоосон өгөөжийн түвшингөөс давсан орлогоор хязгаарлагдаж байгаа тул НАТ-ын тогтолцоо нь гажуудлыг бий болгох магадлал бага юм.



Г. Дүгнэлт

- 22. Монгол Улсын ашигт малтмалын нөөцийг зөв зохистой ашиглаж чадвал төсөвт ихээхэн хэмжээний орлого төвлөрөх боломжтой болох ба улмаар эдийн засгийн өргөн хүрээний асуудлыг шийдвэрлэхэд нэн дөхөмтэй болох юм.** Энэхүү баримт бичигт шинжилгээ хийсэн төслийн ӨЦҮЦ 9.7 тэрбум ам.доллараас илүү буюу 2007 оны ДНБ-ий 240 хувь юм. Ийм төрлийн төсөл хэрэгжүүлснээр ашигт малтмалын салбараас төсөвт орох орлого нь ядуурлыг бууруулах, эдийн засгийг төрөлжүүлэх зэрэг зайлшгүй хийх шаардлагатай эдийн засгийн шинэчлэлийг санхүүжүүлэх томоохон эх үүсвэр болох юм.
- 23. Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдыг татах чадавхи нь сүүлийн жилүүдэд бага зэрэг буурсан нь ГАТ-ыг нэвтрүүлсэн болон улс хувь эзэмшигчээр оролцож эхэлсэнтэй холбоотой юм.** Татварын ахиуц хувь хэмжээ хэт өндөр, зардлыг нь тооцдоггүй зэрэг ГАТ-ын бүтцийн сул талууд нь хувийн хөрөнгө оруулагчдын Монгол Улсын уул уурхайн салбарын бизнесийн орчны тухай ойлголтод сөргөөр нөлөөлсөн юм. Мөн түүнчлэн улсын хувь эзэмшлийн асуудлаар тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь уул уурхайн салбарын төсвийн тогтолцооны тогтвортой байдал, ил тод байдлын талаарх асуудлыг хөндөж байна.
- 24. Уул уурхайн чиглэлийн татварын тогтолцоог өөрчилснөөр хөрөнгө оруулагчдын үр өгөөжийг болон засгийн газрын орлогыг ихээр нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр зарим сул талуудыг засах боломжтой юм.** Ашигт малтмалын нөхөн сэргээгдэхгүй шинжийг харгалзан засгийн газар нь ашигт малтмалаа ашиглуулсаныхаа төлөө эдийн засгийн үр өгөөжийн тодорхой хувийг хүртдэг байх асуудалд анхаарах нь чухал юм. Уул уурхайн

салбарын хэтийн ирээдүйг хамгаалах үүднээс Монгол Улс ГАТ болон улсын хувь эзэмшлийн оролцоо зэрэг орлого хуваарилах арга хэмжээгээ илүү оновчтой болгох гэх мэт уул уурхайн салбарын өнөөгийн төсвийн тогтолцоог сайжруулах хэрэгтэй. Ялангуяа, үр дүнтэй (прогрессив) болон үр ашигтай (ашигийн) зэрэг шинж чанартай НАТ нь өнөөгийн орлого хуваарилах арга хэмжээний оронд нэвтрүүлэх өөр хувилбар байж болох юм.

25. Монгол Улсын өмнө тулгараад байгаа төсвийн холбогдолтой олон асуудлыг шийдвэрлэхийн тулд ашигт малтмалын баялгийн удирдлагыг сайжруулах өргөн хүрээний алхамыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Олон улсын туршлагаас үзэхэд ашигт малтмалын салбарын огцом хөгжил нь үр ашиггүй бөгөөд төлөвлөгдөөгүй гэнэтийн зарцуулалтын шийдвэр гаргахад нөлөөлж улмаар төсвийн болон макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг. Ялангуяа төсвийн тогтолцоо нь төсвийн бодлогын дунд хугацааны тодорхой чиглэлээр хангах чадваргүй орнуудад энэ байдал илүүтэй тохиолддог байна.²⁵ Эдгээр бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс төсвийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал, өнөөгийн болон ирээдүй хойч үеийн хоорондын тэгш байдал зэрэг бодлогын зорилтуудыг тооцож үзсэн үр ашигтай төсвийн тогтолцоогоо бий болгох хэрэгтэй.

²⁵ Зарим орнууд ирээдүйд орох орлогоо тооцоолон их хэмжээний зээл авсан (тухайлбал Венесуэл), зарим нь цалин болон нийгмийн халамжийн салбарт ихээхэн зардал гаргасан (тухайлбал Нигер) бол зарим орнууд эдийн засгийн маш бага өгөөжтэй томоохон улсын хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлсэн байна (тухайлбал Алжир, Иран). Дэлгэрэнгүйг Вакеман-Линн болон бусад (2004)-аас үзнэ үү.

Ашигласан ном

Чакир, С ба А.Клемм, 2007, “Монгол Улсын урт хугацааны төсвийн тогтвортой байдал,” 2007 оны Сонгогдсон Асуудлууд, ОУВС Улсын тайлан 07/39 (Вашингтон: Олон улсын валютын сан)

Фрейзерийн Хүрээлэн, 2007, Фрейзерийн хүрээлэнгийн Уул уурхайн компаниудын жил болгоны судалгаа 2006/2007,

(Ванкувер)

http://www.fraserinstitute.org/commerce.web/publication_details.aspx?pubID=3195 үзнэ үү.

Олон улсын валютын сан, 2008, Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын тухай судалгаа, 4 сар, (Вашингтон: Олон улсын валютын сан)

Айванхоу Майнз, 2005, “Оюу Толгой Төсөл, Монгол Улс – Дэлгэрэнгүй хөгжлийн төлөвлөгөө, Ерөнхий дүгнэлт,” (Улаанбаатар, Монгол Улс)

-----, 2007, Оюу Толгой алт, зэсний төсөл, Монгол Улсын өмнөд хэсэг, (Улаанбаатар, Монгол Улс), <http://www.ivanhoe-mines.com/s/TurquoiseHill.asp> үзнэ үү.

Нээлттэй нийгэмлэг хүрээлэн, 2007, “Монгол Улсын Засгийн газар, Айванхоу Майнз Монголиа Инк. Хооронд байгуулахаар санал болгосон хөрөнгө оруулалтын гэрээний шинжилгээ,” (Улаанбаатар, Монгол Улс)

Вакеман-Линн, Ж., С.Атурупане, С.Даннингер, К.Гвенетадзе, Н.Хобдари ба Е.ЛеБорн, 2004, Газрын тосны баялгийг ашиглах нь: Азербайжаны жишээ (Вашингтон: Олон улсын валютын сан).

II. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБА БА ЦАЛИН ХӨЛС²⁶


A. Удиртгал

26. 1990 оноос хойш Монголын улсын салбарт томоохон өөрчлөлтүүд гарсан билээ.

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээр эдийн засаг дахь улсын салбарын үүрэг роль ихээхэн буурсан. Улмаар 1993 онд ДНБ-ий 52 ½ хувийг эзэлж байсан засгийн газрын зардал 1997 онд 34 ½ хувь хүртлээ буурсан бөгөөд энэхүү бууралтыг дагалдан төрийн албан хаагчдын орон тоог ихээр (13.4 хувь буюу 21,145 төрийн албан хаагч) цөөлсөн билээ. 1990 онд эхлүүлсэн төрийн захиргааны болон төрийн албаны шинэчлэлийн үйл явц гол төлөв төрийн байгууллын шинэ бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, үүнтэй холбогдсон эрх зүйн болон бодлогын хүрээг бий болгоход төвлөрч байсан билээ. 1993-2000 онуудад шинэчлэлийн гол цөм нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд 2000 оноос Монгол Улсын төрийн албаны институцийн чадавхи болон үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах нь шийдэх гол асуудлын нэг болсон юм.

27. Шинэчлэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч Монгол Улсын төрийн алба


нүсэр хэвээрээ байгаа бөгөөд төрийн үйлчилгээний алба хэт давамгайлсан бүтэцтэй ба цалингийн нягтрал өндөр байна. Мөн түүнчлэн 2008 оны төсвийн дагуу 2008 онд улсаас цалинд зарцуулах хөрөнгийн хэмжээ ДНБ-ий 10.3 хувийг эзлэхээр байна. Энэ нь бусад орнуудтай харьцуулахад нэлээд өндөр хувь юм. Цалингийн сан өндөр байгаа болон бусад зардлууд эрчимтэй өсч байгаа нь төсвийн дунд хугацааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүйг харуулж байна. Тус баримт бичигт төрийн ажил эрхлэлт болон цалин хөлс, эдгээрт гарсан сүүлийн үеийн өөрчлөлтүүд, Засгийн газраас төрийн албаны чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг судлаж үзсэн бөгөөд хэтийн ирээдүйд авч хэрэгжүүлэх зарим бодлогын санал дэвшүүлэв.



²⁶ Буянхишигийн Хулан (ОУВС-гийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар) болон Бьюнг Күүн Жанг нар бэлтгэв.


Б. Төрийн ажил эрхлэлт болон цалин хөлсний сүүлийн үеийн хандлагууд

28. **Монгол Улсын төрийн алба хэмжээний хувьд харьцангуй нүсэр юм. Төрийн албан хаагчдын нийт хүн амд эзлэх хувь сүүлийн 8 жилийн туршид тогтмол байсан бөгөөд 2007 оны эцэст хүн амын 5.1 хувь, нийт ажил эрхлэлтийн 13 хувь буюу нийтдээ 135,175 хүн төрийн албанд ажиллаж байна.** Олон улсын түвшинд нийт ажил эрхлэлт болон хүн амд төрийн албан хаагчдын эзлэх хувь хэмжээ тус тус 11 болон 4.7 хувь байдаг. Улсын салбарын цар хүрээ нь дэд бүтэц тааруухан хөгжсөн, цөөн хүн сууршсан өргөн уудам газар нутагт зайлшгүй шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэхтэй холбоотой гарч байгаа зардлын тусгал юм. Төрийн албан хаагчдын 60 гаруй хувь нь орон нутагт харьяалагддаг байна.²⁷



29. **Улсын ажил эрхлэлтийн бүтцийг салбараар нь авч үзвэл 2000-07 онд бараг өөрчлөгдөөгүй бөгөөд нийт ажиллагчдын ихэнх нь эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж байна.** Сангийн яамны мэдээллийн дагуу нийт 2007 онд улсын салбарт 135,175 хүн ажиллаж байсан бөгөөд үүнээс 47,019 (35 хувь) хүн боловсролын салбарт, 23,998 (18 хувь) хүн эрүүл мэндийн салбарт, 16,353 (12 хувь) олон нийгмийн дэг журам, аюулгүй байдлын салбарт, 15,845 (12 хувь) хүн төрийн албанд ажиллаж байна.

²⁷ 2007 оны төрийн албаны тооллого, 12 хуудас.



30. Төрийн үйлчилгээний албан хаагчид хангалттай байгаа ч мэргэшсэн албан хаагчид дутагдалтай байгаа юм. Төрийн албаны тухай хууль (2002)-иар төрийн албыг дөрвөн ангилалд хувааж байна. Үүнд: (i) улс төрийн алба (үүнд, улсын их хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд, Засаг дарга нар), (ii) төрийн захиргааны алба (төв болон орон нутгийн байгууллагын албан хаагчид), (iii) төрийн тусгай алба (шүүх засаглал, цагдаа, батлан хамгаалах, дипломат ажилтан болон төв банк, статистикийн газрын дээд удирдах албан тушаалтнууд), (iv) төрийн үйлчилгээний алба (багш, эмч, сувилагч, цэвэрлэгч, судалгааны ажилтан, механикч, номын санч, жолооч болон бусад төрийн үйлчилгээний төсөвт байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд). 2003-07 оны хооронд улс төрийн албан тушаалтнуудын тоо хэвээр байсан бол төрийн үйлчилгээний алба, төрийн тусгай болон төрийн захиргааны үйлчилгээний албан тушаалын тоо 7.9 хувь, 15.3 хувь болон 29.6 хувиар тус тус өссөн байна. Төрийн албаны бүтцийн хувьд улсад ажиллаж байгаа хүмүүсийн 72.5 хувь нь төрийн үйлчилгээний, 7.2 хувь нь төрийн захиргааны, 18.1 хувь нь төрийн тусгай албанд ажиллаж байна. Нийтдээ 1.9 хувь буюу 2,600 хүн улс төрийн албан тушаал хашиж байна. Үйлчилгээний салбарын ажилчдын тоо өндөр байгаа нь цаашид үр ашгийг нэмэгдүүлэх, эсвэл гэрээний үндсэн дээр төрийн зарим үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх боломж байгааг илтгэж байна.

31. Сүүлийн жилүүдэд төрийн албан хаагчдын цалингийн сан эрчимтэй өсч байгаа бөгөөд бусад орнуудынхтай харьцуулбал маш өндөр түвшинд байгаа юм. Цалингийн сангийн өсөлт 2001-05 онуудад ДНБ-ий өсөлтийг гүйцэх хэмжээнд биш байсан хэдий ч 2005 оноос хойш цалингийн сан маш хурдан өссөн бөгөөд 2008 онд 89 хувьд хүрэхээр байна. Улмаар энэ нь төрийн албан хаагчдын бодит цалин сүүлийн жилүүдэд огцом өсөхөд нөлөөлсөн байна. Түүхий эдийн барааны үнэ өсөхийн зэрэгцээ улсын төсөвт орох ашигт малтмалын орлого нэмэгдэж төсвийн байдал сайжирсан нь Засгийн газарт төрийн албан хаагчдын цалинг 2006 оноос эхлэн их хэмжээгээр нэмэгдүүлэх бололцоог олгосон юм. Цалингийн хэмжээ нь нийт засгийн газрын зардалд эзлэх хувь хэмжээ нь 2000 онд 20 хувь байсан бол 2006 онд 16 хувь болон буурсан байна. Цалингийн сан нь 2000 онд нийт төсвийн зарлагын 20 хувийг эзэлж байсан бол 2006 онд 16 хувь болтлоо буурсан байна. Гэсэн хэдий ч өнгөрсөн 2 жилийн хугацаанд цалин хөлсийг их хэмжээгээр нэмэгдүүлсний

үр дүнд цалингийн сан 2008 онд ДНБ-ий 10.8 хувь, нийт зарлагын 21.8 хувьд хүрэхээр байна.

Төрийн албаны бүтэц (мянган албан хаагч)					
	2003	2004	2005	2006	2007
Улс төрийн алба	2.6	2.6	2.6	2.7	2.6
Төрийн захиргааны алба	8.1	9.3	9.7	9.9	10.5
Төрийн тусгай алба	22.1	22.9	23.6	24.1	25.5
Төрийн үйлчилгээний алба	94.3	90.1	88.9	89.7	101.8
Үүнээс : Зэрэглэл I 2/	16.1
Зэрэглэл II 3/	8.5
Зэрэглэл III 4/	12.4
Зэрэглэл VI 5/	30.5
Зэрэглэл IV, V, VII-XIV	34.3
Нийт	127.1	124.9	124.8	126.4	140.4

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл.

1/ Төрийн үйлчилгээний алба нь 14 зэрэглэлтэй. Төсвийн байгууллагын удирдах болон бусад мэргэжлийн албан тушаалтнууд өндөр зэрэглэлд хамрагддаг.

2/ хамгаалагчид, үүдний сахиулууд, зөөгчид, цэвэрлэгчид, кондукторууд, лифтны засварчингууд, галч гэх мэт ордог.


3/ нягтлан бодогч, операторчин, мужаан, бичээч, үсчин, цэцэрлэгийн багшийн туслах, номын санч гэх мэт ордог.

4/ жолооч, цахилгаанчин, зурагчин, агуулах хариуцагч, сувилагч, орон нутгийн соёлын төвийн бүжиг дэглээч гэх мэт ордог.

5/ инженер, хүүхдийн цэцэрлэг болон бага ангийн багш, нягтлан бодогчид, эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн ажилтан гэх мэт.

Эдгээр үзүүлэлтүүд нь Азид ДНБ-ий 5.3 хувь болон нийт зарлагын 20 хувь, Зүүн Европ болон Төв Азийн орнуудад 3.9 хувь болон 12.6 хувь байдаг байна. Энэхүү цалингийн сангийн өсөлтийг хязгаарлахгүй бол дунд хугацаанд төсвийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй юм.

32. Олон жилийн турш төрийн албан хаагчдын дундаж цалин улсын дундаж цалинтай харьцуулахад доогуур байсан боловч энэ хандлага 2006 оноос эхлэн өөрчлөгдсөн.²⁸




Үндэсний статистикийн газар (ҮСГ)-аас сүүлд явуулсан судалгаагаар 2007 онд улсад ажиллагсдын дундаж сарын цалин улсын дундаж цалин болох 173,000 төгрөг (148 ам.доллар)-өөс бага хэмжээгээр²⁹ давж гарсан бол төрийн өмчийн байгууллагад ажиллагчдын дундаж цалин улсын дундажаас хамаагүй өндөр байгаа дүнтэй

гарсан байна. Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг улсын дундаж цалинд ойртуулж байгаа нь төрийн албанд чадварлаг ажилчдыг татах, үлдээн ажиллуулахад дөхөм болж байгаа ч сүүлийн хоёр жилийн хугацаанд төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг хурдацтайгаар нэмэгдүүлсэн нь эргээд хувийн салбарын цалинг (ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарын ажиллагчдын) нэмэгдүүлэх дарамт үзүүлж эхэлсэн бөгөөд инфляцийн дарамтыг нэмэгдүүлсээр байна.

²⁸ Хувийн хэвшлийн цалингийн түвшингийн талаар албан ёсны мэдээлэл байхгүй. Гэвч Үндэсний статистикийн газраас улирал болгон дундаж цалингийн судалгааг авдаг. Энэхүү судалгаанд эрх зүйн статус болон эзэмшлийн хэлбэрээр нь ангилсан аж ахуйн нэгж байгууллагуудын дундаж цалингийн түвшин болон үндэсний дундаж цалингийн түвшинг тайлагнасан байна. Сүүлийн судалгаанд ойролцоогоор 1,035 аж ахуйн нэгж, 172,900 ажилтныг оролцуулсан байна.

²⁹ 2000-08 онуудад төрийн албан хаагчдын дундаж цалин нь цалингийн доод хэмжээнээс дунджаар 2.4 дахин их, тэтгэврийн доод хэмжээнээс 3 дахин их байсан юм. Тэтгэврийн доод хэмжээг 2000 онд сарын 16,000 төгрөг байсныг 2008 онд 81,000 төгрөг болгон өсгөсөн бөгөөд 2000 онд цалингийн доод хэмжээг 18,000 төгрөг (17 ам.доллар)-нөөс 2008 онд 108,000 төгрөг (92 ам.доллар) болтол өсгөсөн байна.



2003–07 Сарын дундаж цалин (мянган төгрөгөөр)					
	2003	2004	2005	2006	2007
Улсын дундаж	81.5	93.1	101.2	127.7	173.0
Төрийн өмчит үйлдвэрийн газар	93.6	114.4	140.1	157.3	200.5
Хувьцаат компани	97.2	104.6	120.2	140.1	157.9
ХХК	72.3	80.7	90.1	114.5	168.7
Хоршоо	43	53.2	62.9	85.2	139.1
Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл	82.5	72.7	63.6	86.4	117.7
Зарим гишүүд хариуцлагатай нөхөрлөл	57.1	60.5	68.4	84.8	106.6
Төсөвт байгууллагууд	71.4	85.9	96.9	124	173.8
Төрийн бус байгууллага	63.8	86.9	90.2	81.2	135.2
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд	131.6	135.1
Төрийн албан хаагчдын цалин	73.7	89.1	94.9	131.1	182.7

Эх үүсвэр: Сангийн яам ба Үндэсний статистикийн газар.

33. **Цалингийн нягтрал нэлээд өндөр байна.** 2004-07 онуудад цалингийн дээд болон доод хэмжээний харьцаа бага буюу 2.7 байсан нь Тайланд (14.4), Филиппин (9.5), Камбожи (5.5) зэрэг орнуудахаас доогуур, харин Индонези (2.0) улсынхаас дээгүүр байна. Цалингийн сүлжээний ангилал болон зэрэглэлийн түвшинг нарийвчлан авч үзвэл цалингийн нягтрал илүү өндөр байгаа нь харагдаж байна. Цалингийн нягтрал өндөр байгаа тохиолдолд мэргэшсэн албан хаагчдыг татан ажиллуулах хүндрэлтэй байдаг билээ. Иймд 2008 оны 1 дүгээр сард Засгийн газар цалингийнхаа нягтралыг багасган харьцааг 3.4 хүргэсэн байна.³⁰ Энэхүү харьцаа нь бусад орнуудад 3-20 хооронд хэлбэлздэг бөгөөд дундажаар 7 байдаг.³¹

³⁰ Улс төрийн өндөр албан тушаалтан (тухайлбал Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд, Сайд, Дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, аймаг, сумын Засаг дарга нар)-уудын цалин ороогүй болно. Оруулсан тохиолдолд харьцаа нь 2008 онд 7.9 хүрнэ.

³¹ Чиаво-Кампо, Салваторе ба бусад (1997)

Төрийн албан хаагчийн цалингийн нягтралын түвшин				
	Доод	Дээд	Нягтрал	
9/22/1999	19,800	66,124	3.3	
10/17/2001	19,800	85,155	4.3	
9/18/2002	32,700	100,500	3.1	
2/18/2004	40,000	108,000	2.7	
5/25/2005	43,000	116,100	2.7	
2/8/2006	55,900	150,930	2.7	
6/28/2006	64,956	175,381	2.7	
1/1/2007	77,947	210,457	2.7	
10/1/2007	101,331	273,594	2.7	
1/1/2008	139,125	470,548	3.4	

Эх сурвалж: Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам

34. Зарим нэг дэвшил гарч байгааг үл харгалзан тэтгэмж, цалингийн нэмэгдэл, урамшууллын тогтолцоо нь маш ээдрээтэй байгаа бөгөөд салбар, агентлагуудын хувьд харилцан уялдаагүй ашиглагддаг байна. Тиймээс төсөв болон нийт цалинд зарцуулж зардалд хэрхэн нөлөөлж байгааг тооцоолж үзэхэд хүндрэлтэй юм. Салбар болгон Улсын Их Хурлаас эсвэл засгийн газраас баталсан өөрийн гэсэн цалингийн нэмэгдэл, урамшуулал тодорхойлох журам заавартай байна. 2007 онд Засгийн газрын зүгээс боловсролын болон эрүүл мэндийн салбарын ажилтнуудын урамшуулал нэмэгдлийг үндсэн цалин дээр нэмж олгох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч тэтгэмж, шагнал урамшуулалд тодорхойлох тогтсон журмыг боловсруулах, цалин болон ажлын гүйцэтгэл хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр цаашид арга хэмжээ авах шаардлагатай байгаа. Бусад орнуудын хувьд үндсэн цалин болон олгож байгаа нийт цалингийн нэмэгдлийн хэмжээ хоорондын харьцаа 80-100 хувь байна.

Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл	
Албан тушаалын ангилал	Нэмэгдлийн нийт хэмжээ (үндсэн цалингийн хувь)
Улс төрийн алба	40-45
Төрийн захиргааны алба	25-75
Төрийн тусгай алба	15-159
Авилгалтай тэмцэх газар	60-115
Шүүх	55-90
Прокурор	48-88
Үндсэн Хуулийн Цэцийн гишүүн	15-40
Хүний эрхийн үндэсний комисс	53-80
Тагнуулын ерөнхий газар	58-147
Цагдаа	40-159
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	41-144
Гааль	55-100
Батлан хамгаалах	40-112
Төрийн үйлчилгээний алба	20-70
Шинжлэх ухааны салбар	20-45
Мэргэжлийн боловсрол	15-50
Бага болон дунд боловсрол	43-70
Эрүүл мэнд	30-70
Соёл урлаг	28-40
Бусад	40-55

Эх үүсвэр: Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам.

В. Бодлогын Чиглэлд Гарсан Гол Дэвслүүд

35. 2004 оны эхээр батлагдсан дунд хугацааны Төрийн албаны шинэчлэлийн стратеги (ТАШС)-ийг хэрэгжүүлэх явцыг удаан хугацаанд хойшлуулсны эцэст 2007 оны 7 дугаар сард засгийн газрын зүгээс ТАШС-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн батлав. ТАШС-т тусгасан стратегийн дөрвөн үндсэн зорилтуудтай уялдуулан хэд хэдэн тодорхой асуудлуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан болно (Шигтгээ II.1). Үүнд (i) төрийн ахлах албан тушаалтнуудыг нээлттэй, өрсөлдөөнт шалгаруулалтаар сонгох үйл ажиллагааг нэвтрүүлэх, (ii) төрийн албаны Хүний нөөцийн менежмент, мэдээллийн системийг байгуулах, (iii) хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг тусгах чадвартай төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх, үр дүнд тулгуурласан болгох зэрэг асуудлууд орсон байна. Бас нэгэн чухал арга хэмжээний нэг бол цалингийн зардлын хяналтын загварыг боловсруулж улмаар энэ загвар нь цалингийн өсөлтийн зардлыг тооцоход дөхөм болох юм..

Шигтгээ II. 1. Төрийн албаны шинэчлэлийн дунд хугацааны стратеги

Монгол Улсын төрийн албаны шинэчлэлийн үндсэн зорилтууд:

- Төсвийн байгууллагуудын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх;
- Төрийн албаны хүний нөөцийн менежментийг сайжруулах;
- Төрийн албаны хамгийн зохистой хэмжээг хангах; ба
- Төрийн албан хаагчдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох.

Эх үүсвэр: Монгол Улсын Төрийн албаны шинэчлэлийн дунд хугацааны стратеги.

36. Засгийн газрын зүгээс одоогийн цалингийн тогтолцооны дутагдлыг арилгах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авч эхлээд байна. Засгийн газрын зүгээс өмнө тодорхойлсон гол дутагдлууд бол (i) төрийн албан хаагчдын цалингийн түвшин доогуур байгаа, (ii) удирдах албан хаагчид болон үйлчилгээний албаны ажилчдын цалингийн нягтралын харьцаа маш бага, (iii) үйлчилгээний албаны ажилтнуудын цалингийн сүлжээ нь ажилтнуудын мэргэшилтэй уялдаагүй, (iv) албан тушаалын ангилал, зэрэг дэвийн тогтолцоо нь хуучирсан. Цалингийн сүлжээний сул талуудыг арилгах зорилгоор 2007 онд Засгийн газар нь ангилал, зэрэг дэв болгоны төрийн албаны албан тушаалын ажлын байрны тодорхойлтыг шинэчлэн хянасан бөгөөд албан тушаалын нэр, салбар болгоны ажлын байрны ангилал, зэрэг дэвийг сайжруулав. Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг дотор нь шинжлэх ухаан, техник мэргэжлийн, бага болон дунд сургуулийн боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, нийтлэг үйлчилгээ гэх мэт 6 ангилан задласан. Үүнтэй холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн нэмэгдлийг үндсэн цалинд нь нэмж оруулсан байна.

37. **Цалингийн нягтралын харьцааг олон улсын стандартад ойртуулахаар өсгөсөн.** Төрийн захиргааны болон үйлчилгээний албаны цалингийн нягтралын харьцааг 2.4- өөс 2.9, 2.4-өөс 3.1 хүртэл тус тус өсгөсөн байна. Өндөр албан тушаал хашиж байгаа ажилтнуудыг урамшуулах зорилгоор засгийн газрын зүгээс төрийн өндөр албан тушаал хашиж байгаа болон шүүх, прокурорын газрын ажилтнуудын цалинг хоёр дахин нэмсэн.
38. **Төрийн албаны зөвлөл гол гурван яамны чиг үүргийн шинжилгээг хийж, Төрийн албан хаагчдын тооллогыг 2007 онд сүүлээр амжилттай хэрэгжүүлэв (Шигтгээ II.2).**³²Боловсон хүчний удирдлагыг сайжруулахад чиглэгдсэн ХНУМС-ийг бий болгоход төрийн албан хаагчдын тооллогын мэдээллийн баазыг ашиглах юм. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Сангийн яамны чиг үүргийн шинжилгээг хийж, улмаар засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан зарим чиг үүргийг нэгтгэх, өөр яамдуудад шилжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлсон байна.

Шигтгээ II. 2. 2007 оны Төрийн албан хаагчдын тооллогын үр дүн

Тооллогоор 4,001 төсвийн байгууллагуудад ажиллаж байгаа 140,359 төрийн албан хаагчийг 2007 оны сүүлээр тоолсон байна. Мөн түүнчлэн 112 өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг байгууллагын 4,247 ажилчдыг тооллогод хамруулсан байна. Тооллогын үр дүнгээс үзвэл:

- Ажлын байрны сэлгэлт болон төрийн албан хаагчдын тооны цэвэр өсөлт өндөр байна;
- Төрийн өндөр албан тушаалтнуудын дунд жендерийн тэнцвэр байхгүй;
- Хүний нөөцийн хөгжил сул байна;
- Төрийн үйлчилгээний болон нийтлэг үйлчилгээний албаны ажиллагчдын тоо өндөр;
- Хүний нөөцийн талаарх журам, албан хаагчдын хувийн дүрмийг сайжруулах шаардлага байна.

Тооллогоор одоогийн төрийн албаны зарим дутагдлыг олж илрүүлсэн бөгөөд зарим тохиолдолд хоёр буюу түүнээс олон албан тушаалыг нэг хүн хашиж байсан, байнгын албан тушаал дээр түр хугацаагаар томилгоо хийх, тангараг өргөх явдлыг үл тоомсорлох явдал гарсан байна. Тооллогын тайланд “үл үзэгдэх”ажилчид, эсвэл цалингийн санг буруу зүйлд ашигласан байх магадлалын талаар дурдаагүй байна.

Эх үүсвэр. 2007 оны Төрийн албан хаагчдын тооллогын тайлан, Монгол Улс.

Г. Дүгнэлт

39. **Төрийн албанд ДНБ-ий 10 гаруй хувийг зарцуулж байгаа нь бусад орнуудтай харьцуулбал өндөр байгаа бөгөөд зардлыг цаашид нэмэгдүүлэх нь төсвийн тогтвортой байдалд хүндрэл учруулах, улсын бусад салбарын зардлыг “шахан бууруулж” болзошгүй юм.** Цалингийн сан өндөр байгаа нь төрийн албан хаагчдын тоо

³² Тооллогыг Дэлхийн банкны Засаглалыг дэмжих төсөл (ЗДТ)-ийн хүрээнд хийсэн.

өндөр байгаа болон саяхан бодит цалингийн хэмжээг өсгөсөнтэй холбоотой юм. Цалингийн нягтралын хувьд өндөр, төрийн алба бүтцийн хувьд үйлчилгээний алба хэт давамгайлсан байдалтай байна.

40. **2004 онд баталсан Төрийн албаны шинэчлэлийн стратегийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.** ТАШС-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, Төрийн албаны тооллого болон гурван яамдын чиг үүргийн шинжилгээг хийж дуусгах зэрэг чухал алхамуудыг Засгийн газар авч хэрэгжүүлээд байна. Хэгийн ирээдүйд төрийн албаны түвшинг оновчтой болгох, хүргэж байгаа үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах зэрэг ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ дараах зүйлүүдийг анхаарах ёстой. Үүнд: (1) тодорхой хугацаагаар шинэ орон тоо бий болгохгүй байх, ингэхдээ зөвхөн төрийн захиргааны гол албан тушаал дээр сонгосон стратегийн ач холбогдолтой ажилтнуудыг ажиллуулах, (2) төрийн албаны орон тооны тухай мэдээллийн санг сайжруулахын тулд ХНММС-ийг бүрэн ажиллуулах, (3) ТАШС-ийг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Төрийн албаны зөвлөл хоорондын уялдааг сайжруулах (4) төрийн үйлчилгээг гэрээлэн хүргэх тухай хуулийг батлуулах, тус хуулийн төслийг дотооддоо хэлэлцэхээр бэлэн болоод байна. Мөн ажил эрхлэлтийн заавар журам ил тод мэргэшсэн төрийн албыг бий болгох зорилгоор Төрийн албаны тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах, (5) төрийн албаны шинэчлэлийг төсвийн дунд хугацааны мэдэгдэлтэй нэгтгэх, төрийн албыг илүү оновчтой болгох үүднээс ТАШС-тай уялдсан төсвийн хувьд олгох боломжтой цалин хөлс, тэтгэмжийн бодлогыг боловсруулах.

Ашигласан ном

Төрийн албаны Зөвлөл, 2004, Монгол Улсын Төрийн албаны шинэчлэлийн дунд хугацааны стратеги (Улаанбаатар, Монгол Улс).

_____, 2007 Төрийн албаны шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Улаанбаатар, Монгол Улс).

_____, 2008 Төрийн албаны тооллогын тайлан (Улаанбаатар, Монгол Улс).

_____ ба П.Д.П. Австрали ПТВ ЛТД, 2007, Цалингийн харьцуулсан шинжилгээний тайлан (Улаанбаатар, Монгол Улс).

Үндэсний статистикийн газар, 2007, Статистикийн тойм (Улаанбаатар, Монгол Улс).

Чиаво-Кампо, Салваторе, Гуйлио де Томмасо, ба Амитабха Мухерже, 1997,

“Улсад ажиллах нь ба цалин хөлс: Дэлхий нийтийн болон бүсийн төлөв байдал,”
Дэлхийн банкны Бодлого, судалгааны баримт бичиг 1771 (Вашингтон, Дэлхийн банк).

НҮБ, 2004, ЗӨАОХ-ны бүсийн орнуудын Төрийн албаны тогтолцоо, Харьцуулсан төлөв байдал (НьюЙорк).

III. МОНГОЛ УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООД³³

А. Удиртгал

41. Монгол Улсын санхүүгийн систем нь 16 арилжааны банк болон 369 банк бус санхүүгийн байгууллагуудаас бүрддэг бөгөөд эдгээр банк бус санхүүгийн байгууллагуудад тусгай зөвшөөрөлтэй 182 хадгаламж, зээлийн хоршоод (ХЗХ), 15 даатгалын компани ба 35 үнэт цаасны компаниуд багтаж байна. Санхүүгийн салбарт банкны салбар давамгайлж 2007 оны эцсийн байдлаар санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 96 хувийг эзэмшиж байв.

	Санхүүгийн салбарын бүтэц, 2004-07								
	2004 оны 12 сар			2006 оны 12 сар			2007 оны 12 сар		
	Тоо	Хөрөнгө (тэрбум төгрөгөөр)	Нийт хөрөнгийн хувь	Тоо	Хөрөнгө (тэрбум төгрөгөөр)	Нийт хөрөнгө хувиар	Тоо	Хөрөнгө (тэрбум төгрөгөөр)	Нийт Хөрөнгө хувиар
Банкууд	17	892	92.2	16	1,899	94.7	16	3,279	95.7
Хувийн	16	16	1,899	94.7	16	3,279	95.7
Улсын	1	57	5.9	0	0	0.0	0	0	0.0
Банк бус санхүүгийн байгууллагууд	684	76	7.8	1,096	107	5.3	369	147	4.3
Даатгалын компаниуд	19	22	1.1	15	28	0.8
Амь даатгал	0	0	0.0	0	0	0.0
Амь даатгал	0	0	0.0	19	22	1.1	15	28	0.8
Хадгалмж зээлийн хоршоо 1/	570	47	4.9	955	16	0.8	182	36	1.0
Санхүүгийн компаниуд / ББСБ	114	29	3.0	122	69	3.4	137	66	1.9
Үнэт цаасны компаниуд / Брокерийн компаниуд	0	0	0.0	0	0	0.0	35	16	0.5
Нийт	701	968	100.0	1,112	2,006	100.0	385	3,426	100.0

Эх үүсвэр: Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо; болон ОУВС-ийн шинжээчдийн тооцоо.
1/ 2007 оны хувьд шинээр гэрчилгээ авсан хадгаламж зээлийн хоршоод.

42. Өмнө нь ХЗХ-ны салбарыг зохицуулж хянах зохистой тогтолцоо байгаагүйгээс олон тооны ХЗХ-дын үйл ажиллагаа доголдож дампуурсан. Энэхүү баримт бичгээр ХЗХ-д үүсч хөгжсөн цагаас хойшхи хөгжлийн явц, 2005-2006 онуудад ХЗХ-ыг дампууралд хүргэсэн гол хүчин зүйлүүд болон эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон танилцуулах юм.

Б. Хямрал болохоос өмнөх ХЗХ-ны салбарын хөгжил

43. Монгол Улсын ХЗХ-ын үйл ажиллагааг 1995 онд хүчин төгөлдөр болсон Хоршооны тухай хуулиар зохицуулдаг. Анхны хүчин төгөлдөр болсон хууль нь хөдөө, аж ахуй, үйлдвэрлэл, хэрэглээ болон маркетингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хоршоодод чиглэгдэн боловсруулагдсан бөгөөд ХЗХ-ын үйл ажиллагааг зохицуулахад тохиромжгүй байсан юм. Тус хуулийг 1998 онд шинэчлэн найруулж 2002, 2005 онуудад ХЗХ-ын шаардлагын тусгах зорилгоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан болно. 2002 онд

³³ Базарбай Ардак (Монгол Улс дахь ОУВС-ийн суурин төлөөлөгчийн газар) болон Бёнг Гюн Жанг нар бэлтгэв.

тус хуулинд нэмэлт өөрчлөлт оруулснаар ХЗХ-ын тоо огцом өсөх нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд 2006 оны дунд үед 900 гаруй ХЗХ-д голцуу Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байжээ.³⁴ Түүнчлэн нийслэл хотод бүртгэлтэй хоршоодын тал гаруй хувь нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа явуулж байсан байна.



44. Монголын хамгийн анхны ХЗХ-д 1996 оны сүүлээр 1997 оны эхээр Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжиж байсан төслийн хүрээнд үүсгэн байгуулагдахад төрийн бус байгууллагуудын оролцоотой чухал байсан. Улс даяар ХЗХ-ны үндэсний сүлжээг байгуулахад дэмжлэг үзүүлэх АХБ-ны өөр нэг төсөл 2002 онд хэрэгжиж эхэлсэн. Төслийг хэрэгжүүлж эхэлсний дараахан ХЗХ-ой холбоотой хүндрэлтэй асуудлууд гарч ирснээр төслийг түр хугацаагаар зогсоож улмаар 2006 онд үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон.³⁵

45. 2006 оны эхээр Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) байгуулагдах хүртэл ХЗХ-д төрийн ямар нэгэн зохицуулалтгүй байж, зохимжгүй дүрэм, журмын дагуу татварын газраас үйл ажиллагаагааг нь хянадаг байсан юм. Хоршооны тухай хуулийг анх баталснаар Монголбанкнаас ХЗХ-ын тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтыг хариуцах болсон бөгөөд арваад хоршоо байгуулах зөвшөөрлийг олгосон юм. 1998 онд Монгол Улсын Их Хурлаас ХЗХ-д тусгай зөвшөөрөл олгох шаардлагыг хүчингүй болгож ХЗХ-ыг улсын бүртгэлд хамруулах эрхийг татварын албанд шилжүүлсэн болно. Хоршооны тухай хуулинд 2002 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ХЗХ-дыг зохицуулах тогтолцоог сайжруулахад ахнаарлаа хандуулсан бөгөөд Монголбанкны зүгээс зохицуулалт хийх эрх үүргийг хэсэгчлэн сэргээсэн. Гэвч ХЗХ-дод хяналт тавьж, холбогдох хариуцлага тооцох асуудал нь татварын албан дээр хэвээр үлдсэн. ХЗХ-ны зохих хууль, эрхзүйн орчин байхгүй байгааг шийдвэрлэх зорилгоор 2006 онд АХБ-ны туслалцаатайгаар ХЗХ-д

³⁴ Нэмэлт, өөрчлөлтөөр зээлийн комиссын эрх, үүрэг, хариуцлага, гишүүнийг уулзалт болон хяналтын зөвлөл зэргийг томъёолов.

³⁵ 8.7 сая ам.долларын санхүүжилттэй Хөдөөгийн санхүүгийн төслийн хүрээнд 330 ХЗХ болон ХЗХ-ны холбоог улс даяар байгуулахад дэмжлэг үзүүлэх байв.

зориулсан хуулийн төслийг (III.1 Хайрцаг) боловсруулсан боловч өнөөг хүртэл Улсын Их Хурлаар батлагдаагүй байна.

В. ХЗХ-ын Дампуурал

46. 2003-2004 он гэхэд ХЗХ-ны салбартай холбоотой таагүй асуудал гарч байгаагийн анхны шинж тэмдэг илрэв. Олон ХЗХ-д хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомжийг зөрчин маш өндөр хүүтэй хадгаламжийн бүтээгдэхүүнээ сурталчилсан. Монголбанкны зүгээс ХЗХ-ны зорилго, үйл ажиллагааны чиглэл, гишүүдийн эрх, үүрэг, өндөр хүүний цаана нуугдаж байгаа бодит эрсдлийн талаар цуврал мэдээллийг гаргасан.³⁶ Түүнчлэн Монголбанкнаас тус салбарын зохицуулалтыг чангатгах, ХЗХ-дыг шинээр бүртгэж гэрчилгээ олгох ажлыг түр хугацаагаар зогсоохыг Сангийн яамнаас хүссэн. Монголбанкнаас ХЗХ-д тодорхой зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангахыг шаардсан журам гаргасан бөгөөд татварын албатай хамтран хяналт шалгалт явуулсан. зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй, санхүүгийн тайлангаа буруу мэдээлсэн, шаардлагын дагуу санхүүгийн тайлангаа татварын байгууллагуудад өгдөггүй, хадгаламж эзэмшигч, гишүүдийнхээ жагсаалтыг гаргах чадваргүй зэрэг зөрчлийг Монголбанкнаас илэрүүлсэн юм. Дээрх асуудлаар цаашид арга хэмжээ авах зорилгоор Улсын Их Хуралд танилцуулсан болно. Гэвч 2004 оны Улсын Их Хурлын сонгууль ойртож байсны улмаас Их Хурлаас ямарваа нэгэн арга хэмжээ аваагүй билээ.

³⁶ Улсын Их Хурлын Тамгын газар (2007)

Шигтгээ II. 1. ХЗХ-ын хуулийн төсөл

2007 онд УИХ-д өргөн барьсан ХЗХ-ны хуулийн төсөлд дараах ХЗХ-ны зохицуулалт, хяналтын тогтолцоог тусгасан юм. Үүнд:

Хуулийн төсөлд ХЗХ-г өөрсдийн гишүүдийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээг хангах зорилгоор хадгаламж, зээлийн үйлчилгээ санал болгож байгаа, нэгдсэн удирдлага, хяналттай ашгийн бус хуулийн этгээд гэж тодорхойлсон байна. Бүртгүүлсэн ХЗХ нь гэрчилгээ аваагүй бол хадгаламж, зээлийн үйл ажиллагаа явуулах эрхгүй. СЗХ гурван жилийн хугацаатай гэрчилгээг олгох бөгөөд ХЗХ нь гэрчилгээгээ авснаас хойш нэг жилийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулаагүй бол гэрчилгээг хүчингүй болгох эрхтэй. СЗХ нь ХЗХ-ыг хяхах байгууллагын хувьд нөөц хөрөнгө бүрдүүлэх зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тогтооно.

ХЗХ-г үүсгэн байгуулагчдын тоо 25 хүрсэн буюу нийт хөрөнгийн 30 дээш хувийг бэлэн мөнгөөр бүрдүүлсэн тохиолдолд байгуулж болно. Зээлийн санхүүжилтийг зөвхөн хадгаламж ашиглан зөвхөн ХЗХ-ны гишүүдэд олгоно. ХЗХ-ны нэг гишүүн болон түүнд холбоотой этгээдэд олгох зээлийн хэмжээ ХЗХ-ны хөрөнгийн 10 хувиас хэтрэх ёсгүй.

ХЗХ-д дараах зүйлийг хориглосон:

- салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- гишүүний ХЗХ-нд оруулсан хөрөнгийг барьцаа болгон авах;
- банк, санхүүгийн байгууллага, гишүүн нь болсон нийтийн хоршооноос бусад тохиолдолд иргэд болон хуулийн этгээдээс зээл авах, өөр эх үүсвэрээс хөрөнгө татах;
- хадгаламж, зээлийн хүүгээ сурталчлах;
- сугалаа зохион байгуулах;
- гишүүд болон гуравдагч этгээдэд барьцаа болон баталгаа гаргах;
- ХЗХ-ны холбоо, нийтийн хоршооноос бусад тохиолдолд хууль, эрх зүйн байгууллагуудад хөрөнгө оруулах; ба
- ХЗХ-ны гишүүнээр хуулийн этгээдийг авах.

Эх үүсвэр: Сангийн яам.

47. 2006 онд хэд хэдэн ХЗХ-д дампуурснаа зарласан бөгөөд мянга мянган хадгаламж эзэмшигчид мөнгө алдсан. Банк бус санхүүгийн байгууллагуудыг хянах зорилгоор байгуулагдснаасаа хойш СЗХ нэн даруй салбарын хяналтын ажлыг эхлүүлсэн ч ХЗХ-д дампуурсан тухай мэдээлэл цацагдсаар байв. Бэлэн мөнгөний дутагдалд орсон томоохон ХЗХ-ны менежер шинээр томилогдсон СЗХ-ны даргын аллагыг үйлдсэнээр нөхцөл байдал улам хурцадсан. 2006 дунд үед хадгаламж эзэмшигчдийн алдагдал 57 тэрбум төгрөг (ДНБ-ий 1.5 хувь буюу 48 сая ам.доллар)-т хүрсэн тухай тайланг СЗХ-оос УИХ-д хийв. Энэхүү мэдэгдлийн үр дүнд ХЗХ-ын нэр хүнд огцом унасан бөгөөд ХЗХ-ын зарим хадгаламжийг арилжааны банкинд шилжүүлэхэд хүрэв. ХЗХ-ын удирдлага холбогдох хууль, тогтоомж мөрдөөгүйгээс, хадгаламж эзэмшигч болон удирдлагад мэдлэг, мэдээлэл байгаагүйгээс

болон Хоршооны тухай хуулинд байсан хуулийн цоорхойг бууруугаар ашиглан нь энэхүү алдагдалд хүргэсэн гэж тайланд тусгасан байсан.


Дампуурсан 29 ХЗХ-ны хохирол

Дампуурсан ХЗХ-ны тоо	29
Хохирогчдын тоо (хадгаламж эзэмшигчид)	8,903
Тооцолсон хохирлын хэмжээ	67.9 тэрбум төгрөг
Зээлийн үлдэгдэл	4.0 тэрбум төгрөг
Битүүмжилсэн хөрөнгийн өртөг	43.0 тэрбум төгрөг

Эх үүсвэр: УИХ-ын Тамгын газар (2007).

Г. Хямралын Дараах Нөхцөл Байдал

48. ХЗХ-ын гишүүдийн зүгээс олон гомдол гарсныг үндэслэн СЗХ нь ХЗХ-ын журам зохицуулалтыг сайжруулж, ХЗХ-д тусгай зөвшөөрөл шинээр олгож эхэлсэн. ХЗХ-ын зохих хууль, тогтоомж байгаагүйгээс СЗХ 2006 онд ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн түр журам гаргав. СЗХ өөрийн зохицуулалт, хяналтын үүргээ гүйцэтгэх үүднээс хэд хэдэн гарын авлага, журам гаргасан бөгөөд ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох үе шатууд болон хяналтын тогтолцоог ил тод болгох, оролцогчдын санал бодлыг тусгасан байх үйл явц дээр анхаарав. 2007 оны эцсээр ойролцоогоор 22,000 гишүүнтэй 182 ХЗХ-д гэрчилгээ олгосон, өргөдлөө өгсөн. 100 ХЗХ-д өргөдлөө өгч, мөн түүнчлэн 50 ХЗХ-д мэдээллээ шинэчлэн өргөлдөө дахин өгөөд байв. Татварын албанд бүртгэлтэй боловч зохих шаардлагын дагуу 2007 оны 10 дугаар сарын 1-ний дотор тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ гаргаагүй 600 орчим ХЗХ-г 2007 онд батлагдсан Хоршооны тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх тухай хуулийн дагуу шүүхийн журмаар татан буулгахаар болсон.



49. Тусгай зөвшөөрөл шинээр авсан ХЗХ-ын ихэнх нь жижиг байгууллагууд хэдий ч тус салбарын нийт өөрийн хөрөнгийн 39 хувь, ашгийн 61½ хувийг нэг ХЗХ бүрдүүлж салбарыг давамгайлж байна. ХЗХ-ын тал хувь нь 100-500 гишүүнтэй бөгөөд

гишүүнчлэлийн хөрөнгө нь 100 сая төгрөг (86,000 ам.доллар)-өөс бага байна. Тус салбарын нийт хөрөнгө 2007 онд хоёр дахин өссөн бөгөөд 2007 оны эцсээр 36 тэрбум төгрөг (ДНБ-ий 0.8 хувь)-т хүрэв. 2007 оны эцэст нийт хөрөнгийн 38 хувийг арилжааны банкинд байршуулсан бэлэн мөнгө, харилцах хадгаламж бүрдүүлж байв. Зээлийн багц нь нийт хөрөнгийн зөвхөн тал хувийг бүрдүүлж байсан нь СЗХ-оос тогтоосон шалгуур үзүүлэлт болох 70-80 хувийн хязгаараас хамаагүй доогуур байв. СЗХ-ноос нэгтгэсэн тайлангаас харахад чанаргүй зээлийн багцийн эзлэх хувь хэмжээ 6 ½ орчимд эргэлдэж эрсдэлийн санг зохих хэмжээнд байгуулсан байсан. Өөрийн хөрөнгийн өгөөж 29 хувьтай байсан бол нийт хөрөнгийн өгөөж 5 хувьтай байв.

2007 оны 12 дугаар сарын байдлаар ХЗХ-дын нэгдсэн баланс (сая төгрөгөөр)			
Актив		Пассив болон Эзэмшигчдын хөрөнгө	
I. Урсгал хөрөнгө	34,082.30	I. Пассив	28,269.30
Бэлэн мөнгө, хадгаламж	13,600.20	Хадгаламж	25,959.70
Зээл	18,037.50	Богино хугацааны зээл	386.8
Авлага	1,959.90	Бусад богино хугацааны пассив	1,807.00
Бусад урсгал хөрөнгө	484.7	Урт хугацааны пасств	115.8
II. Урсгал бус хөрөнгө	1,545.30	II. Эзэмшигчийн хөрөнгө	7,358.20
Томол хөрөнгө	1,318.50	Хувьцаат хөрөнгө	6,513.60
Бусад урсгал бус хөрөнгө	226.8	Хоршооны гишүүдийн эд хөрөнгө	844.6
Нийт хөрөнгө	35,627.50	Нийт пассив болон хөрөнгө	35,627.50

Эх үүсвэр: СЗХ.

50. Олон нийтийн өсөн нэмэгдэж буй эсэргүйцлийн улмаас 2007 оны 4 сард засгийн газар 29 ХЗХ-ны хадгаламж эзэмшигчдэд нөхөн олговор олгох шийдвэр гаргав. Нөхөн олговор шаардахын зэрэгцээгээр ХЗХ-ын хяналтыг хангалттай хэмжээнд тавиагүйгээс хохирол учруулсан хариуцлагыг засгийн газар хүлээх ёстой гэсэн байр суурийг хадгаламж эзэмшигчид баримтлаж байв. Нилээд хугацаанд улс төрийн хэлэлцүүлэг явагдасны эцэст улсын төсвөөс олгосон хөрөнгийг битүүмжилсэн эд хөрөнгийг борлуулах замаар нөхөн төлнө гэсэг нөхцөлтэйгээр дампуурсан 29 ХЗХ-ны хадгаламж эзэмшигчдийн алдагдлын 50 хувь (ойролцоогоор 68 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувь)-ийг Хохирлыг барагдуулах тухай хуулийн дагуу улсын төсвөөс гаргахаар болсон.³⁷ Өнөөг хүртэл 20 ХЗХ-ны хэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн бөгөөд ХЗХ-оос битүүмжилсэн авсан хөрөнгийн хэмжээ нь засгийн газраас олгосон нөхөн олговрын хэмжээнээс хамаагүй доогуур байгаа нь харагдаж байна.

³⁷ Алдагдлын нөхөн олгох тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлж байх үед дахин 5 ХЗХ дампуурсан. Тус хуулиар эдгээр 5 ХЗХ-ны нөхөн олговрыг хамруулаагүй болно.

**ХЗХ-ын хохирлыг барагдуулах нөхөн олговор
(2008 оны 3 сарын байдлаар)**

Нөхөн олговорын хууль батлагдсан	2007 оны 8 сарын 3
Нөхөн олговорыг олгож эхэлсэн	2007 оны 10 сарын 19
Нийт нөхөн олговор (хуулийн дагуу)	33.0 тэрбум төгрөг
Шүүхийн шийдвэр гарсан нь	20 ХЗХ-д
Нийт нөхөн олговор (шүүхийн шийдвэрийн дагуу)	34.2 тэрбум төгрөг
Олгосон нөхөн олговор	22.7 тэрбум төгрөг
Буцааж авах бэлэн мөнгө болон эд хөрөнгөөс олох мөнгө	1.7 тэрбум төгрөг

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар.

Д. Дүгнэлт

51. **Сүүлийн жилүүдэд ХЗХ салбар зохих хяналт, зохицуулалтын тогтолцоогүй огцом өссөний улмаас 2005-2006 онуудад 30 гаруй ХЗХ дампуурсан юм.** 2006 оны эхээр СЗХ-г байгуулагдтал, ХЗХ-д нь ямарч зохицуулалтгүй байсан бөгөөд маш өндөр хадгаламжийн хүү амлан банкны салбартай өрсөлдөж байсан юм. Тиймээс 2006 онд тус салбарын нийт хөрөнгийн тал хувийг эзэлдэг 30 гаруй ХЗХ-д дампуурсан юм. Эхэн үед эсэргүйцэж байсан хэдий ч засгийн газар хадгаламж эзэмшигчдийн хохирлын 50 хувийг нөхөн олгохоор болов.
52. **Банк бус санхүүгийн салбарыг хянахын тулд СЗХ-г зохих эх үүсвэрээр хангах хэрэгтэй бөгөөд ХЗХ-ны салбарын хууль эрх зүйн салбарыг сайжруулах хэрэгтэй.** СЗХ нь байгуулагдснаасаа хойш олон саад бэрхшээлтэй тулгарч байсан ч банк бус санхүүгийн салбарын хууль эрх зүй, зохицуулалт болон хяналтын орчныг сайжруулах чиглэлээр хэд хэдэн санаачлага гарган дэвшил гаргасан юм. 1000 орчим байгууллагыг хянах үүрэгтэй ч СЗХ нь өөрийн байгууллагын чадавхийг сайжруулахын тулд туршлагатай мэргэжилтэн, эх үүсвэр, тус салбарын статистик мэдээ болон сургалтаа нэмэгдүүлэхэд хангалттай эх үүсвэр байхгүй байгаа юм. Банк бус санхүүгийн байгууллагын хөгжлийн өнөөгийг түвшинд засгийн газраас СЗХ-ны үйл ажиллагааг төсвийн эх үүсвэрээр дэмжих нь чухал юм. 2006 онд АХБ-ны тусламжтайгаар боловсруулсан ХЗХ-ны хуулийн төслийг өнөөг хүртэл батлаагүй байгаа. Энэхүү хуулийн батлахаас өмнө ХЗХ-ны салбарын санал бодлыг сонсож, тус хуулийн хэрэгжилтийг хангахын тулд 2006 оноос хяналтыг хэрэгжүүлсэн СЗХ-ны туршлагыг тусгах нь чухал юм. СЗХ-ны хяналт шалгалтын ажилтнуудыг хуулийн хүрээнд нэмж хамгаалах шаардлагатай байна.

Ашигласан ном

Азийн хөгжлийн банк, 2001, Монгол Улсад санал болгосон Хөдөөгийн Санхүү төслийн талаар Захирлуудын зөвлөлийн даргын тайлан, зөвлөмж (Манила: Азийн хөгжлийн банк).

-----, 2002, Бичилсанхүүгийн гол асуудал, 5-7 хуудас (Манила: Азийн хөгжлийн банк).

Монголбанк, 2007, Сарын Бюлетень, 12 сар (Улаанбаатар).

Сангийн яам, 2007, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төсөл (Улаанбаатар, Монгол Улс).

Санхүүгийн зохицуулах хороо, 2007, ХЗХ газрын 2007 оны үйл ажиллагааны тайлан (Улаанбаатар, Монгол Улс).

-----, 2007, “2007 оны 3 улирлын ХЗХ-ын нэгдсэн санхүүгийн тайлан” (Улаанбаатар, Монгол Улс).

Улсын Их Хурал, 2007, Буцааж өгөх нөхцөлтэйгээр алдагдлын нөхөн олговор” (Улаанбаатар)

Улсын Их Хурлын Тамгын газар, 2007, 2007 оны 5 сарын 8-ны хурлын тэмдэглэл, Монгол Улсын Их Хурал (Улаанбаатар).

Улсын Их Хурлын ажлын хэсэг, 2006, ХЗХ-ны тухай хуулийн хэрэгжилт, ХЗХ-ын дампуурах болсон нөхцлийн тухай тайлан, Монгол Улсын Их Хурал (Улаанбаатар).

Дэлхийн банк, 2008, Санхүүгийн салбарыг тогтворжуулах, шинэчлэх нь (Вашингтон)

www.worldbank.org үзэв.

IV. 2001 оны ЗГССГА-ыг Ашиглан Монгол Улсын Төсвийн Мэдээллийн Тухай Танилцуулга, Урьдчилсан Дүн

53. **2005 оны 11 сарын 16-ны өдрийн Гүйцэтгэх зөвлөлийн семинараар Захирлууд Засгийн газрын Санхүүгийн Статистикийн гарын авлага (ЗГССГА)-ын тогтолцоог ашиглах нь тухайн улс орны төсвийн мэдээллийн ил тод байдал, уялдаа холбоог илүүтэйгээр хангана гэж үзсэн (Шигтгээ IV.1).** Энэхүү баримт бичгээр Ази, Номхон Далайн орнуудын³⁸ нэг болох Монгол Улсад хийсэн туршилтын судалгааны үр дүнг тайлагнах юм. Тус судалгааны зорилго нь 2001 оны ЗГССГА-ын үйл ажиллагааны тайлан, нэгдсэн баланс, бэлэн мөнгөний тайлан зэргийг Дүрмийн IV дэхь хэлэлцүүлгийн тайланд нэгтгэх явдал юм. ЗГССГА-ын шинжилгээний тогтолцоо нь актив, пассивын өөрчлөлтүүд мөнгөн урсгалын үр дагавар бөгөөд эдгээр нь гүйлгээ эсвэл бусад эдийн засгийн урсгал байж болох юм. Гарсан тайлан болгон төсвийн дөрвөн үзүүлэлт (цэвэр үйл ажиллагааны баланс, цэвэр зээл, зээлдүүлэг, цэвэр хөрөнгө, бэлэн мөнгөний ашиг/алдагдал)-ийг агуулдаг ба эдгээр үзүүлэлтүүд нь гишүүн орнуудад төсвийн бодлого, төсвийн хөгжилд мониторинг хийхэд туслалцаа үзүүлэх юм. Тус тогтолцоо нь хяналт ажиглалтын хөтөлбөрийн хүрээнд тайлан тэнцлийн аргыг сайжруулах гэсэн Сангийн хүчин чармайлттай уялдаж, улмаар төсвийн тайлагналтыг ил тод болгох олон улсын стандартыг сайжруулах явдалтай бүрэн нийцэж байгаа юм.³⁹
54. **Засгийн газрын нэгдсэн төсвийн мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийхэд суурь болгон 2001 ЗГССГА-ыг ашиглах нь Монгол Улсын хувьд дунд хугацаанд тохиромжтой гэдгийг туршилтын судалгаагаар харуулж байна.** Албан ёсны мэдээллийг 2001 оны ЗГССГА-ын зарчим, томъёололтой уялдуулах шаардлагатай ч шинээр тогтоох, нарийвчилсан мэдээллийг шаардсан салбаруудад нягтлангийн тогтолцоо, тайлангийн форматыг ашиглах боломжтой юм. 2001 оны ЗГССГА-г бүрэн шилжихийн тулд тасралтгүй хүчин чармайлт гаргах шаардлагатай бөгөөд ялангуяа мэдээллийн эх үүсвэр, ЗГСС гарцыг цаг тухайд нь сайжруулах зорилгоор Сангийн яамны ахлах мэргэжилтэнгүүдээр удирдуулсан байвал зохистой.
55. **Тус баримт бичигт шинжилгээний үнэ цэнэ нь төсвийн үндсэн үзүүлэлтүүд болон улсын салбарын ЗГС хүснэгтүүдээс урган гарсан тэнцвэржүүлэх зүйлээс урган гарч байгааг дүгнэж байна.** 2005/2006 оны санхүүгийн жилийн санхүүгийн бус хөрөнгө, санхүүгийн актив, пассивын холбогдох мэдээллийг 2006 оны урсгалд нарийвчилсан мэдээллийг нэгтгэсний үр дүнд мэдээллийн дутмаг байдлыг илрүүлж, мөн мэдээллийн

³⁸Бүсийн Газар болгоноос хоёр орныг сонгосон юм. АНДГ-аас сонгогдсон хоёр дахь орон бол Австрали.

³⁹ Стандарт, хуулиудыг мөрдөх тухай тайлангийн мэдээллийн загварын хувьд 2001 оны ЗГССГА нь төсвийн мэдээллийн арга зүйн зөв байдлыг сөргүүлэн үнэлдэг стандарт юм. Үүний адилаар Төсвийн ил тод байдлын тухай гарын авлага нь 2001 оны ЗГССГА дээр суурилсан төсвийн тайлагналтыг зөвлөмж болгосон байдаг. Сангийн мэдээллийн стандартын санаачлагын сүүлийн хяналтаар 2001 оны ЗГССГА нэвтрүүлэхийг дэмжсэн.

уялдааг сайжруулав. 2001 оны ЗГССГА-ын зарчимтай нийцсэн засгийн газрын цэвэр хөрөнгийг тооцон гаргах ерөнхий хэмжигдэхүүнийг боловсруулах суурийг тавьсан гэсэн урьдчилсан дүн гарсан юм.⁴⁰ Түүнчлэн боловсруулсан статистикийн хүснэгтүүд нь санхүүгийн бус төрийн салбарыг хамарсан бөгөөд өргөн хүрээний нэгжүүдийг оролцуулсан төсвийн дансны хамрах цар хүрээг өргөжүүлсэн баттай суурийг хангах байгаа юм. Монгол Улсын туршилтын судалгааны байгууллагын хамрах хүрээ болон статистикийн мэдээллийг нэгтгэхэд ашиглагдсан мэдээллийн эх үүсвэрийн талаар А хэсэгт дурьдсан байгаа. В хэсэгт 2006 оны мэдээллийг ашигласны үндсэнд гарсан гол ололтуудыг дурьдсан байгаа. С хэсэгт нэмэлт арга хэмжээний тухай тусгасан.

Шигтгээ IV.1.. Туршилтын судалгааны суурь мэдээлэл

2005 оны 11 сард гүйцэтгэх захирлуудын семинараар хамтарсан статистик, төсвийн асуудал эрхэлсэн газрын “2001 оны ЗГССГА-ын статистикийн тогтолцоог ашиглан Сандахь төсвийн шинжилгээг сайжруулах нь” баримт бичгийг батлав. 2001 оны ЗГССГА-ын статистикийн тогтолцоо (Хавсралт I үзнэ үү)г ашиглах нь шинжээчдийн тайлан дахь тухайн улс болгоны төсвийн мэдээллийг илүү ил тод байдал, уялдааг хангахад хүргэнэ гэдгийг Захирлууд тэмдэглээд, дараах зүйлийг тохиров. Үүнд:

- Үндсэндээ, шинжээчдийн тайланд 2001 оны ЗГССГА-ын статистикийн тогтолцоог ашиглан төсвийн мэдээллийг танилцуулахын тулд үе шатаар ахих хэрэгтэй.
- 2001 оны ЗГССГА-ын үйл ажиллагааны тайлан, нэгдсэн баланс, бэлэн мөнгөний тайлан зэргийг Дүрмийн IV Зүйлийн хэлэлцүүлгийн тайланд оруулахын тулд туршилтын судалгаа явуулна. Туршилтын судалгааг сайн дурын орнуудад хоёр жилийн турш Сангийн төсвийн хүрээнд 2001 оны ЗГССГА-ын тогтолцоонд шилжих үйл явцыг илүү тодорхой тогтоож, ЗГСС системийг ашиглан төсвийн мэдээ тайлангаа нэгтгээд эхэлсэн орон (ойролцоогоор 100)-уудаас мэдээлэл цуглуулан хийх юм.
- Туршилтын судалгаа, Сангийн үйл ажиллагааны үндэс болгон 2001 оны ЗГССГА-ын арга зүйг бүрэн хэрэгжүүлэх үйл ажлын явцын хамт 2008 онд шинжээчид Зөвлөлд тайлагнана.

Хэлэлцүүлгийн дэлгэрэнгүйг дараах сайтаас үзнэ үү

<http://www.imf.org/external/np/pp/eng/2005/102505.pdf> and the Public Information Notice (PIN) No. 05/167 available online at <http://www.imf.org/external/np/sec/pn/2005/pn05167.htm>.

⁴⁰ 1986 оны Засгийн газрын Санхүүгийн Статистикийн гарын авлага (ЗГССГА 1986) тогтолцооны эрс тэс ялгаа байгаа ч гишүүн орнууд болон Санд тус тогтолцоог өргөнөөр ашигласан хэвээр байгаа бөгөөд (санхүүжилтийн) дээд болон доод эгнээг нэгтгэх үйлдлээр хязгаарлагддаг бөгөөд мөнгөн урсгал, хуримтлагдсан дүнг нэгтгэх боломжгүй.

А. Ерөнхий асуудлууд

- 56. Байгалийн баялгийн ач холбогдол нэмэгдэж байгаатай холбогдон эдгээр санхүүгийн бус хөрөнгийг төсөвт тусгах зорилгоор хэмжих, удирдах зэрэг асуудал дээр тулгуурлан АНДГ болон Монгол Улсын холбогдох байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр Монгол Улсыг туршилтын судалгаанд хамруулахаар сонгосон юм.** Засгийн газрын үйл ажиллагааны мөнгөн урсгал дээр гол анхаарлаа хандуулдаг Сангийн судалгааг явуулахад Монгол Улсын төсвийн суурь мэдээлэл хангалттай гэж АНДГ-аас үзсэн юм. Сангийн шинжээчид улсын өрийн ДӨҮЦ-ийг нэгтгэх, ЗГСС-ийн тогтолцоон дахь актив, пассивын байгаа мэдээллийг бүрэн нэгтгэснээр төсвийн тогтвортой байдлын шинжилгээг хийх боломжтой болох юм. Түүнчлэн засгийн газрын бэлэн мөнгөний хязгаарлалтыг тодорхойлох, төсвийн болон мөнгөний статистикийг нэгтгэх, 2001 оны ЗГССГА-ын тогтолцооны дагуу бэлэн мөнгөн дээр суурилсан статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох нь хүндрэлтэй байв.
- 57. Нягтлан бодох бүртгэлд гарсан дэвшил, олон улсын нягтлангийн стандартад илүү дөхөм болсон санхүүгийн тайлагналтанд анхаарлаа хандуулсан нь эрх бүхий байгууллагуудын зүгээс төрийн цэвэр хөрөнгийг тодорхойлох найдвартай арга хэлбэрийг бий болгох нөхцлийн хангаж байна.** Бодлогын шинжилгээг 2001 оны ЗГССГА-ын арга зүйтэй уялдуулах нь Монгол Улсын төсвийн бодлогын урт хугацааны тогтвортой байдлыг үнэлэх нэгдсэн тогтолцоо, улс орны газар доор байгаа баялаг, бүтцийн өөрчлөлтийн зардал, хувьчлалын үйл ажиллагаа зэргийг үнэлэх баттай суурь болох юм.⁴¹
- 58. Туршилтын судалгаанд улсын салбарын байгууллага (төсвийн данс, төсвөөс гадуурх сангууд, нийгмийн хамгааллын сангууд болон эдгээр байгууллагуудын орон нутгийн салбарууд нь)-уудыг хамарсан юм.** Сангийн яамны Төрийн сан эдгээр салбаруудын тодорхой зүйдүүдэд хамаарах бэлэн мөнгөөр хийгдсэн гүйлгээний мэдээллийг нэгтгэдэг.⁴² Үүнээс тусад нь аккруел суурьтай хугацаа нь дуусгавар болсны санхүүгийн бус хөрөнгийн хувьцаа, актив болон пассивын мэдээллийг нэгтгэж байгаа юм (тус улсын нягтлан бодох арга зүйг талаар шигтгээ IV.2.-т дурьдсан). Энэхүү мэдээлэл нь нийгмийн хамгааллаас бусад дэд салбарын гүйлгээг тооцох суурь болох юм.

⁴¹Шинжээчдийн 2006 оны тайлангийн дагуу 2003-06 онуудад ашигт малтмалын баялгийг ашиглаж эхэлсэн явдал нь уул уурхайн салбарын орлого долоо дахин нэмэгдсэн бөгөөд 2006 оны санхүүгийн жилд улсын салбарын албан хаагчдын цалингийн хувь хэмжээ 30 хувиар өсгөхийн зэрэгцээгээр нийгмийн халамжийн шилжүүлэг, зардал их хэмжээгээр тэлсэн болно.

⁴² 2001 оны ЗГССГА-ын арга зүй тогтолцооны дээд эгнээний гүйлгээнд орлого, зарлага, санхүүгийн бус хөрөнгийн цэвэр худалдан авалт орно.

Б. Үр дүн

59. Одоогоор байгаа мэдээллийн эх үүсвэрийг төсвийн үйл ажиллагаанд шинжилгээ хийх боломжоор хангах, өөр хоорондоо холбоотой бөгөөд уялдаа бүхий төсвийн статистик мэдээллийн багцыг боловсруулахад ашиглах юм. 2001 оны ЗГССГА-ын тогтолцоог хэрэгжүүлснээр Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг сайжруулахыг зэрэгцээгээр үндсэн балансад орсон өөрчлөлтүүдээс үүдэн улсын салбарын пассивыг илүү сайн үнэлэх ажил дээр анхаарлаа хандуулан ажиллах боломжийг шинжээчдэд олгож байгаа юм. Энэхүү хэсэгт дурьдсан хэвтээ (урсгал, хуримтлагдсан дүн) болон босоо (цэвэр зээл, цэвэр зээлдүүлэг, санхүүжилт) интеграцчилалын мэдээллийг боловсруулах боломжгүй байсан юм. Шигтгээ IV.3-т дүн шинжилгээний хувьд ач холбогдол бүхий үндсэн үзүүлэлт, балансын тайлбарыг статистик хүснэгтээр хавсаргав (IV.1, IV.2, IV.3, IV.4 хүснэгтүүд).

Шигтгээ IV.2. Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн практикийн товч

2007 оны Дүрмийн IV Зүйлийн Шинжээчдийн тайланд Монгол Улсын төсвийн тогтолцоо 2006 оны эхний үеэс нилээд хувьсаж ирсэн. Энэ болон бусад хөгжил, дэвшлийн тусгал нь хүний, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, НӨАТ тухай хууль болон экспортын бараа, бүтээгдэхүүний өндөр үнийн улмаас уул уурхайн компаниудын орлогоос төсөвт орлого татах зорилгоор шинээр нэвтрүүлсэн гэнэтийн ашгийн татвар зэрэг арга хэмжээнүүд юм. ГАШ-ийн татварын орлогоор Хөгжлийн сан байгуулагдсан бөгөөд тус сангийн орлогыг дараах байдлаар хуваарилсан байна. Үүнд: (i) гуравны нэгийг нь хадгаламжинд; (ii) гуравны нэгийг нь хөрөнгө оруулалтын зардал; and (iii) гуравны нэг нь айл, өрхүүдэд чиглэгдсэн нийгмийн хөтөлбөрт юм. Хувьсаж буй төсвийн тогтолцоон дээрээ суурилан эрх баригчид нягтлан бодох бүртгэл болон мэдээллийг ангилах, олон улсын стандартад нийцсэн нэгтгэлийн арга зүйг нэвтрүүлэх чиглэл рүү шилжих санаатай байгаагаа илэрхийлсэн.

Сангийн яам (Төрийн сан)-наас нэгтгэсэн төсвийн мэдээлэл нь зөвхөн бэлэн мөнгөн дээр суурилсан бөгөөд ЗГСС-ийн стандартчилалыг бүрэн мөрдөөгүй гэсэн тайлан АНДГ-т ирсэн. Энэхүү багц мэдээлэл нь ирээдүйн төсөөллийг оролцуулан сангийн шинжээчдийн тайланд танилцуулсан төсвийн мэдээллийн анхдагч эх үүсвэр юм. Аккруел суурьтай бүрэн багц данс байхгүйгээс туршалтын судалгааны үеэр боловсруулсан хүснэгтэнд аккруел суурьтай, Сангийн яамнаас нэгтгэсэн бөгөөд орлого, зарлагыг тооцоолж байж, мөн санхүүжилт болон бэлэн мөнгөн дээр суурилсан нягтлан бодох бүртгэлийг гаргаж байж хувьцааны мэдээллийг ашиглах юм. Сангийн яамны хувьцааны мэдээллийн эх үүсвэрээс гадна цэвэр хөрөнгийг тогтоох боломжин дээр үндэслэн 2001 оны ЗГССГА-ын тогтолцоотой уялдаж байгаа анхан шатны мэдээллийг гаргах боломжтой болсон юм. Хувьцааны мэдээллийг дэд салбарын мэдээллийг нэгтгэсэн байдлаар харуулсан бол бодит байдал дээр орлого, зарлага нь дэд салбар болгон дээр тусад нь харуулсан байдаг. Энэ нөхцөл байдлын улмаас улсын салбарын үйл ажиллагааны нэгтгэлийг 2001 оны ЗГССГА-ын тогтолцоогоор ашигласан талаарх санал, гомдлыг хүлээн авахад хүндрэлтэй байдалд хүргэв.

60. IV.1.Хүснэгтэнд 2004-06 оны хугацаанд Балансын өөрчлөлт, шинэчлэл хэрхэн явагдсаныг харж болох бөгөөд актив, пассивын оны эцэс дэх байдлын талаарх нарийвчлалтай мэдээллийн санг боловсруулах асуудлыг эрх баригчид сайн мэдэж байгаа. Одоогийн балансанд тусгаагүй байгаа Монгол Улсын засгийн газар эзэмшдэг ихээхэн хэмжээний үйлдвэрлэгдээгүй активыг үл харгалзсан ч улсын цэвэр хөрөнгө

нэмэгдсэн нь баталгаажсан юм (ДНБ-ий 18.4 хувиас 37.3 хувь хүртэл).⁴³ Энэ нь их хэмжээний өр барагдуулсан ба гадаад мөнгөн тэмдэгтээр зээлсэн зээлийн үлдэгдэл ДНБ-ий 75.7 хувиас 44.0 хувь хүртэл буурсантай холбоотой юм. Эдгээр өөрчлөлт, шинэчлэлийг дагалдан цэвэр санхүүгийн хөрөнгө (санхүүгийн активаас пассив хасах) нь цэвэр зээллэгээсээ сайжирсан буюу 2004 онд ДНБ-ий -29.1 хувиас 2006 онд ДНБ-ий -4.8 хүртэл буурсан байна.

61. 2006 оны хуримтлагдсан дүн болон урсгалын хуучин мэдээллийг нэгтгэх буюу босоо интеграцчилалын үр дүнд IV.2. хүснэгтэд харуулсан тоон өгөгдлийг гаргаж авсан юм.

2001 оны ЗГССГА-ын тогтолцоог зөв нэвтрүүлж байгаа тохиолдолд үнэ болон хэмжээний өөрчлөлт (ашиг, алдагдал болон хэмжээний өөрчлөлтүүд)-үүд хувьцааны актив, пассивт хэрхэн нөлөөлж байгааг тодорхой харуулдаг. Монгол Улсын хувьд санхүүгийн бус хөрөнгийн хуримтлагдсан дүн, урсгалын мэдээлэл анхдагч шатандаа явж байгаа, нягтлан бодох бүртгэлийн үед санхүүгийн актив, пассивын гүйлгээний мэдээллийг нэгтгэхэд сул талууд байсаар байгаа (13 хэсэгт хийсэн хэлэлцүүлгийг үзнэ үү) бөгөөд эрх баригчид цэвэр хөрөнгөд нөлөөлж байгаа холбогдох гүйлгээг тодорхойлохын тулд жилийн эцсийн түвшингийн зөрүүгээр тогтоож байна. IV.2. Хүснэгтэд заасны дагуу гүйлгээгээр дамжуулсан санхүүгийн бус актив нэмэгдэж байгаа нь хөрөнгө, бараа бүтээгдэхүүн худалдан авалтын хувьд 2006 оны хаалтын балансантай уялдуулж болохгүй юм. Хувьцааны түвшинд суурилан санхүүгийн актив, пассивын гүйлгээний тооцооны мэдээлэлд “гадаад валютад шилжүүлсний зөрүү”-г оруулдаг бөгөөд зөрүүг оруулсан үед эрх баригчдын зүгээс тооцоолсон цэвэр үнийг тусад нь тодорхойлдоггүй.

62. Засгийн газрын үйл ажиллагааны тайлан (IV.3 Хүснэгт)-д 2006 оны турш санхүүгийн гүйцэтгэл маш байсныг илтгэж байна. ДНБ-ий 15.2 хувьтай тэнцэх нийт үйл ажиллагааны баланс (НҮАБ)⁴⁴ -аар хэмждэг засгийн газрын хадгаламж нь ДНБ-ий 9.3 хувийг бүрдүүлж байсан нь санхүүгийн бус активт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс илүү байв. Үүний үр дүнд цэвэр зээлдүүлэг (ЦЗ)⁴⁵ ДНБ-ий 5.9 хувьд хүрэв. Нийт үйл ажиллагааны илүүдэл нь 2006 онд улсын салбарын цэвэр хөрөнгө нэмэгдэхэд хүргэсэн бөгөөд энэхүү үр дагавар нь Засгийн газрын балансанд тусгагдсан байна. Цэвэр хөрөнгө (2004-06) байнга өсөж байгаа нь төсвийн бодлогын тогтвортой байдлыг илтгэж байгаа юм.

⁴³ АНДГ-ын төсвийн мэдээнээс 2004 онд ДНБ 2,152 тэрбум төгрөг, 2005 онд 2,780 болон 2006 онд 3,715.

⁴⁴ Орлогоос Зардлаа хасаж, эрх баригчдаас тооцоолж байгаагүй тогтсон хөрөнгийн хэрэглээнээс бусад.

⁴⁵ 2001 оны ЗГССГА-ын нийт үйл ажиллагааны баланс (НҮАБ) болон цэвэр зээлдүүлэг (ЦЗ) нь урсгал болон ерөнхий балансын уялдаа холбоо бүхий хамтрагчид билээ. Туршилтын судалгаагаар НҮАР нь ДНБ-ий 15.2 хувь гэдгийг тогтоосон бөгөөд тус үзүүлэлт нь 2008 оны Шинжээчдийн тайланд тусгасан 2006 оны засгийн газрын урсгал баланстай болох ДНБ-ийн 14.8 хувьтай их ойролцоо байв.

63. **Босоо интеграцилалд түгээмэл, бараг бүх салбарт ЦЗ болон санхүүжилтийн мэдээллийн хооронд зөрчил гарч байгаа нь мэдээллээ баталгаажуулах, энэхүү судалгаанд тодорхойлсон хоосон зайг нөхөх ажлыг хийх шаардлагатайг харуулж байна.** IV.2.Хүснэгтэд 2006 оны хувьд гүйлгээний улмаас гарсан цэвэр хөрөнгө болон цэвэр санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтүүд нь IV.2. хүснэгтэнд тусгасан нийт үйл ажиллагааны баланс болон ЦЗ-ээс ялгагдаж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. IV.2.хүснэгтэнд тусгагдсан улсын салбарын статистикийн зөрүү нь IV.3.хүснэгтэнд тооцоолсонтой бүрэн уялдаж байгаа бөгөөд үүнийг эх мэдээллийн сангаар баталгаажуулж байгаа юм. Өөр журам ашиглан нэгтгэдэг засгийн газрын үйл ажиллагаа (орлого ба зарлага) бол санхүүжилт (санхүүгийн активын цэвэр худалдан авалтаас хасах нь цэвэр пассив)-ын мэдээллийг дахин оруулахад эрх баригчдын зүгээс тайлагнасан нийт үйл ажиллагааны баланс (НҮАБ)-ыг илүү нарийвчлалтай болгохын тулд мэдээллийн эх үүсвэрийн санд өөрчлөлт, зохицуулалт хийх шаардлагатай юм. Засгийн газрын нэгдсэн мэдээлэл нь статистикийн зөрүү ДНБ-ийн 1.8 хувийг эзэлж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь одоогоор ашиглагдаж байгаа дотоод санхүүгийн тайлагналын тогтолцоо болон 2001 оны ЗГССГА-д тулгуурласан статистикийн мэдээ цуглуулах үйл явц хоорондын уялдааг сайжруулах боломжтой юм. Энэхүү нөхцөл байдлыг засгийн газрын нэгжүүдэд хийгдсэн гүйлгээг нэгтгэх асуудлаар нотолсон бөгөөд тус гүйлгээний үр дүнд нийт орлогын болон зардал нь АНДГ-ын тайланд тусгасан тоо, хэмжээнээс зөрсөөр байв.⁴⁶
64. **Оны эцэс дэх дүн, урсгалын мэдээллийн дүн шинжилгээг өргөжүүлсэн хөгжлийн дасгалын хувьд туршилтын судалгааны хүрээнд Бэлэн мөнгөний эх үүсвэр, түүний хэрэглээний тухай тайланг 2007 оны мэдээллийг ашиглан боловсруулав (IV.4. Хүснэгт).** Тус тайлангийн гол зорилго нь бэлэн мөнгөний гүйлгээнээс урган гарсан нийт илүүдлийг бэлэн мөнгөний бус амлалтуудыг тусгасан цэвэр зээллэгтэй хэрхэн харьцуулалт хийх вэ гэсэн асуудал юм. 2006 болон 2007 оны засгийн газрын бэлэн мөнгөний илүүдэл байгаа нь засгийн газар бэлэн мөнгөөр хязгаарлагдаагүй бөгөөд аккруел болон бэлэн мөнгөний суурь дээр үндэслэн тооцоолсон төсвийн хэрэгжилтийг харьцуулж болно гэдгийг илтгэж байна.⁴⁷ Нягтлан болох бүртгэлийн практикт байгаа он удаан жилийн тулгамдсан асуудлуудын улмаас жил болгон засгийн газрын пассив, бэлэн мөнгөний хуримтлалд гарсан өөрчлөлтүүдэд нөлөөлж байгаа санхүүжилтийн үндсэн хүчин зүйлийн өөрчлөлт, дэвшлийг илүү ойлгох байдлыг хязгаарладаг гэдгийн эрх баригчид хүлээн зөвшөөрч байгаа.
65. **IV.4.хүснэгтэнд тусгаснаар бэлэн мөнгөний хуримтлалын цэвэр өөрчлөлтийг сар болгон тодорхойлох гэсэн хүчин чармайлт нь амжилтыг хязгаарлав.** Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт болон АНДГ-т тайлагнах зорилгоор эрх баригчид бэлэн мөнгөний балансанд гарч байгаа өөрчлөлтүүд болон сар болгоны мэдээлэл тайлангийн системд баланс барих зорилгоор банкны системын цэвэр зээлийг тооцож байна. 2001 оны

46

47

ЗГССГА болон шинжилгээний тогтолцоонд мэдээллийг дахин оруулахад 2007 оны сар болгоны бэлэн мөнгөний гүйлгээтэй холбоотой мэдээлэл нь тухайн санхүүгийн жилийн бэлэн мөнгөний хуримтлалын цэвэр өөрчлөлтийг тэгээр илэрхийлэх юм. Энэхүү тааруухан үр дүнгээр пассивын дүн шинжилгээ хийх, 2001 оны ЗГССГА-ын бэлэн мөнгөн дээр суурийг үндэслэсэн тайлангийн үндсэн онцлог болох санхүүгийн жилийн турш төсвийн болон мөнгөний бодлогыг хамтатган авч үзэхэд эрх баригчдын чадварт шууд нөлөөлөх санхүүгийн гүйлгээний ангилалд гарсан алдааг тусгасан юм. Нягтлан бодох бүртгэлийн практикт алдаагаа засаж байх үед болон санхүүжилтийн үндсэн бүрэлдэхүүнийн талаар мэдээлэл байгаа эсэх асуудлаар бэлэн мөнгөний илүүдлийн хэмжээний талаар тодорхой дүгнэлт гаргахад энэхүү хичээл дэмжлэг болох юм.⁴⁸

В. Дараагийн алхамууд

